

# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО,  
ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-т заасны дагуу Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичиж жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэдэг. 2016 оны жилийн төлөвлөгөөнд энэхүү 15 дахь илтгэлийг боловсруулж УИХ-д хүргүүлэх, олон нийтэд сурталчилах ажлын хүрээнд 5 ажил төлөвлөсөн нь бүрэн хэрэгжсэн байна. Мөн 16 дахь илтгэлийн сэдэв болон илтгэл боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хэлэлцүүлсэн байна.

- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлийг 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Илтгэл өргөн барьсантай холбогдуулан дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:
- 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдөр илтгэлийг олон нийтэд сурталчилах зорилгоор хэвлэлийн бага хурал хийв. Уг хуралд нийтдээ 18 хэвлэл мэдээллийн хэрэгсэл ирж мэдээ, сурвалжлага бэлтгэсэн. Үүнд өдөр тутмын сонин 2, радио 1, мэдээллийн сайт 2, 13 телевиз оролцсон болно.
- 15 дахь илтгэлийг 4 дүгээр сарын 1-ний өдөр Комиссын болон УИХ-ын албан ёсны цахим хуудаст байршуулав.
- Илтгэлийн бүлэг бүрээр тусгай нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд сурталчилахаар МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгтэй хамтран ажиллаж эхний нэвтрүүлэг 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр гарсан.
- Илтгэлийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2016.04.15-ны өдрийн №14/923/ дугаарт хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгов.
- 15 дахь илтгэлийг монгол хэлээр 1500 хувь, англи хэлээр 200 хувь хэвлүүлж холбогдох бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын, эрдэм шинжилгээний байгууллага, нийтийн болон их дээд сургуулиудын номын сан зэрэг 114 байгууллагад 1078 хувийг хүргүүлж, Комиссоос зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд хэрэглэж байна.


## 1.2.Хяналт шалгалт

Комисс 2016 онд нийт 111 хяналт шалгалт зохион байгуулсан байна.

№		Шалгалт хийсэн объект	Дүн	Авсан арга хэмжээ
1	төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу	ШШГЕГ-ын харьяа хорих анги	5	Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй шалтгаан, нөхцлийг арилгуулахаар ЗӨВЛӨМЖ,
2		Цагдан хорих байр	39	
3		Баривчлах, саатуулах байр	6	
4		ХХЕГ-ын харьяа цэргийн анги	15	
5		ЗХЖШ-ын харьяа цэргийн анги	25	

6		Хилийн боомт /Гашуун сухайт, Шивээ хүрэн/	2	илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар холбогдох албан тушаалтанд тус тус ШААРДЛАГА хүргүүлж хуулийн хугацаанд хариу ирүүлсэн байна.
7		Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй 8 компани /Оюутолгой, Энержи ресурс, МАК, Эрдэнэс таван толгой, Таван толгой, Саусгоби сэндс, Чинхуа Мак-Нарийн сухайт, Хайрхан толгой коал/	8	
8	Гомдол, мэдээллийн мөрөөр	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2, 5 дугаар цэцэрлэг	1	
9		Хурдан морины унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийн асуудал	1	
10		“МОНЭНЗИМ” ХХК	1	
11		Эрүүл мэндийн яамны харьяа Хүүхдийн төв сувилал	1	
12		Дорнод аймгийн Дорнод их сургууль	1	
13		МҮОНРТ	1	
14		Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл	1	
15		ШШГЕГ-ын харьяа хорих 421 дүгээр анги	1	
16		ШШГЕГ-ын харьяа хорих 401 дүгээр анги	1	
17		Төв аймаг дахь ШШГА-ны цагдан хорих байр	1	
Нийт			111	

Хяналт шалгалтын тоон мэдээллийг өмнөх онуудтай харьцуулбал:



**Төвлөрсөн хорих анги, цагдан хорих байр, захиргааны журмаар албадан саатуулах, баривчлах байранд хяналт шалгалт зохион байгуулах хүрээнд**

- Комиссын гишүүн П.Оюунчимэг ахлан Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Т.Ихтамир, ахлах референт Л.Дүгэрсүрэн, референт Б.Сэмжидмаа,

Х.Цэцгээ нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тусгай удирдамжийн дагуу ШШГЕГ-ын харьяа Хорих 415 дугаар ангид ялтны эрхийн хэрэгжилт болон тус ангид ажиллаж буй албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр тус тус хяналт шалгалт хийв. Хяналт шалгалтын дүнгийн хурал хийж, Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлсэн.

- ШШГЕГ-ын харьяа Дархан-Уул аймгийн хорих 445, 435-р ангиудад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадоржоор ахлуулсан ажлын хэсэг 2015 оны 1 дүгээр сарын 14, 15-ний өдрүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд тус тус хяналт шалгалт хийв.
- Мөн орон нутаг дахь ахлах мэргэжилтнүүд аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны Цагдан хорих байранд нийт 39, аймгийн Цагдаагийн газрын харьяа Захиргааны журмаар баривчлах, саатуулах байранд 6 удаа хяналт шалгалт хийсэн байна.

Үүнд: Цагдан хорих байранд Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн ахлах мэргэжилтэн тус бүр 2, Увс аймгийн ахлах мэргэжилтэн 4, Архангай, Дорноговь, Өвөрхангай, Төв, Ховд аймгийн ахлах мэргэжилтэн тус бүр 1 удаа, Захиргааны журмаар баривчлах, саатуулах байранд Баянхонгор, Булган, Говь-Алтай, Сүхбаатар, Төв, Увс аймгийн ахлах мэргэжилтэн тус бүр 1 удаа хяналт шалгалт хийсэн байна.

Тахарын ерөнхий газартай байгуулсан Санамж бичгийн хүрээнд хуяглан хүргэлтийн автомашин нь стандартад нийцэж буй эсэхэд хяналт шалгалт зохион байгуулахаар төлөвлөсний дагуу Комиссын гишүүн П.Оюунчимэг ахлан Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга, ажилтнууд, 21 аймаг дахь ахлах мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тусгай удирдамжийн дагуу 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар Хууль зүйн сайд болон Тахарын ерөнхий газрын даргад Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлсэн. Хариу ирүүлсэн. Зөвлөмжийн үндэслэл биелэгдсэн байна.

Хил хамгаалах ерөнхий газартай байгуулсан хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд 2016 оны 05 дугаар сараас 10 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Улаанбаатар хүрээний 7 анги, Дорнод, Дорноговь аймгийн Замын-Үүд дэх, Өмнөговь аймаг, Гурвантэс сум, Увс, Ховд аймгийн Үенч сум дахь, Баян-Өлгий аймаг дахь 2 анги, Хилийн цэргийн нийт 15 ангид ажиллаж буй албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт болон хугацаат цэргийн албан хаагчийн эрхийн хэрэгжилтэд тус тус хяналт шалгалт зохион байгуулав. Үүнд:

Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Хилийн цэргийн 0132 дугаар ангид ажиллаж буй албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, хугацаат цэргийн албан хаагчдын эрхийн хэрэгжилтэд 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдөр, Өмнөговь аймагт байрлах 131 дүгээр анги болон тус аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт байрлах 166 дугаар ангид 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдүүдэд, Улаанбаатар хүрээний Хилийн цэргийн 164, 151, 218, 288, 253, 303, 252 дүгээр ангиудад 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд, Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Хилийн цэргийн 108 дугаар анги, мөн Увс аймаг дахь Хилийн цэргийн 245 дугаар ангид 2016 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 09 дүгээр сарын 24-ны өдрүүдэд, Ховд аймгийн Үенч сум дахь Хилийн цэргийн 130 дугаар ангид 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр, Баян-Өлгий аймаг дахь Хилийн цэргийн 165, 285 дугаар цэргийн ангид албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт болон хугацаат цэргийн албан

хаагчийн эрхийн хэрэгжилтэд 2016 оны 09 дүгээр сарын 25-наас 28-ны өдрүүдэд тус тус хяналт шалгалт хийв.

Зэвсэгт хүчний жанжин штабтай байгуулсан хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд ЗХЖШ-ын харьяа нийт 25 анги байгууллагад ажиллаж буй албан хаагчдын хөдөлмөрлөх эрх болон хугацаат цэргийн албан хаагчдын эрхийн хэрэгжилтэд тус тус хяналт шалгалт, судалгаа хийв. Үүнд: 2016 оны 4 дүгээр сард Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа Зэвсэгт хүчний 065, 084, 189, 284, 310, 015, 029, 120, 326, 013, 016 дугаар ангид, 2016 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Баянхонгор аймаг дахь Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид, 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Завхан аймаг дахь Зэвсэгт хүчний 325 дугаар ангид, 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Дорнод аймаг дахь Зэвсэгт хүчний 327 дугаар ангид, Сүхбаатар аймаг дахь Зэвсэгт хүчний 146 ангид, 9 дүгээр сард Ховд, Баян-Өлгий аймаг дахь Зэвсэгт хүчний 167, 123, 340 дүгээр ангид, Налайх дүүрэг дэх ЗХ-ний 353, 350, 014, 337 дугаар ангид 11 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд тус тус ажиллаж албан хаагчдын хөдөлмөрлөх эрх болон хугацаат цэргийн албан хаагчдын эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт, судалгаа хийв.

Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэг Өмнөговь аймгийн 3 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн сайтуудад хүний эрхийн хэрэгжилттэй танилцав.

**Гомдол, мэдээллийн мөрөөр дараахь 10 хяналт шалгалт хийв. Үүнд:**

- ШШГЕГ-ын харьяа Хорих 401 дүгээр ангийн Тогтоол гүйцэтгэх ерөнхий газрын Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч эмнэлгийн ажилтнуудад ажлын байрны дарамт үзүүлэх, хөдөлмөрлөх эрх зөрчиж байгаатай холбоотой гомдлыг нэр бүхий 21 иргэн ирүүлсний дагуу 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр тус ангид ажилтны хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, ШШГЕГ-т зөвлөмж хүргүүлэв.
- Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Төв аймаг дахь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Албаны Цагдан хорих байрны орчин нөхцөл, цагдан хоригдогчдын эрхийн хэрэгжилтэд 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн ахлах референт Л.Дүгэрсүрэн, референт Э.Баярбаатар, Комиссын Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн У.Чойжилсүрэн нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалт хийв.
- Дорнод аймгийн Дорнод их сургуульд ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2016 оны 3 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд ахлах референт Х.Мөнхзул, Дорнод аймаг дахь ахлах мэргэжилтэн Д.Дугарсүрэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалт хийж, илтгэх хуудас боловсруулав.
- Хүй долоон худагт болсон Дүнжингарав хурдан морины уралдааны явцад унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийн асуудлаар ахлах референт Л.Дүгэрсүрэн, референт Ж.Очирбат, хэвлэлийн ажилтан С.Будрагчаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг мэдээллийн мөрөөр 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдөр хяналт шалгалт хийж, дүнг Комиссын даргад илтгэх хуудсаар танилцуулав.
- МҮОНРТ-ийн захиргааны ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд гомдлын мөрөөр 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хяналт шалгалт хийв.
- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ажилтнуудаас ирүүлсэн гомдлын дагуу тус байгууллагад ажлын байрны дарамт, хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт, ажилтнуудаас авсан санал асуулга, баримт бичигт дүн шинжилгээ хийж ажилтнуудтай хийсэн

ярилцлагаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар Комиссын гишүүн 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 2/11 дугаар Зөвлөмжийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга болон Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн даргад тус тус хүргүүлэв. Зөвлөмжийн хариуг хуулийн хугацаанд ирүүлсэн. Зөвлөмж биелэгдсэн байна.

- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хоёр, тав дугаар цэцэрлэгэд ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хяналт шалгалт хийж, хоёрдугаар цэцэрлэгийн эрхлэгчид Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлсэн байна.
- Комисс, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газартай хамтран 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр “Монэнзим” ХХК-ийн ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, ажлын байрны дарамт, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийв.
- Мэдээллийн мөрөөр 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэг Эрүүл мэндийн яамны харьяа Хүүхдийн төв сувилалд асруулагчдын эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн.

СЭМҮТ, ШШГЕГ-ын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар, Улаанбаатар хотын Цагдаагийн газрын харьяа Түр хамгаалах байранд Комиссын гишүүн П.Оюунчимэгээр ахлуулсан ажлын хэсэг 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр СЭМҮТ-д эмчлүүлэгчдийн эрхийн хэрэгжилтэд, Улаанбаатар хотын Цагдаагийн газрын харьяа Түр хамгаалах байранд 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр тус тус хяналт шалгалт хийв. Хяналт шалгалтын дүнгийн хурал хийж, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж хүргүүлсэн болно.

**Нэмэлт:** Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах Гашуун сухайт хилийн боомт, Гурван тэс суманд байрлах Шивээ хүрэн хилийн боомтын үйл ажиллагаа, тэнд ажиллаж буй ажилтан, албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн нөхцөл байдалтай 2016 оны 09 дүгээр сарын 05-12-ныг хүртэлх хугацаанд танилцаж, тодорхой асуудлыг шийдвэрлүүлэхээр Гаалийн ерөнхий газрын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарт 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлэв.

**Нэмэлт:** Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй Оюутолгой ХХК, Энержи ресурс ХХК, Эрдэнэс таван толгой ХХК, Таван толгой ХХК, Саусгоби Сэндс ХХК, Мак ХХК, Чинхуа Мак-Нарийн Сухайт ХХК, Хайрхан толгой коал ХХК-д ажиллаж буй ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийв. Дундговь, Өмнөговь аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, удирдлагууд, төрийн албан хаагчид, тус аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, иргэдтэй бүлгийн болон ганцаарчилсан уулзалт ярилцлага хийж, мэдээлэл цуглуулав.

### **1.3 Судалгаа, дүн шинжилгээ**

Комисс хууль, тогтоомжийн төсөлд санал өгөх, хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийхэд онцлон анхаарч, “Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх ажлын хэсэг” байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг нь Улсын Их Хуралд өргөн баригдсан, хэлэлцэгдэж буй хууль, тогтоомжийн төсөлтэй цаг тухай бүр танилцан 2016 онд нийт 22 хууль, бодлогын баримт бичгийн төсөлд холбогдох саналаа гаргаж УИХ, Засгийн газар, яамдад хүргүүлсэн байна. Үүнд:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл 2016.02.05
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016.02.19
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2016.02.24
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд 2016.02.24

5. Бүгд Найрамдах Беларусь Улс, Монгол Улс хооронд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай 2016.02.26
6. Бүгд Найрамдах Беларусь Улс, Монгол Улс хооронд иргэний болон худалдааны асуудлаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай, 2016.02.26
7. Бүгд Найрамдах Беларусь Улс, Монгол Улс хооронд ялтан шилжүүлэх тухай гэрээнүүдийн төсөл 2016.02.26
8. “Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5823:2013, 2016.04.21
9. “Хөгжлийн бэршээлтэй иргэдийн асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5798:2008 стандартууд 2016.04.21
10. Хууль зүйн сайдын тушаалаар баталсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам” 2016.05.11
11. “Цагдан хорих байр, хорих ангийг нүүлгэн шилжүүлэх ажиллагааны үед хуяглан хүргэх ажиллагаа явуулах журам” 2016.05.11
12. “Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам” 2016.05.11
13. “Биечилсэн хамгаалалтын журам” 2016.05.11
14. Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам” 2016.05.11
15. “Тахарын албаны алба хаагчийн биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх түр журам” 2016.05.11
16. Төрөөс залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2016.05.16
17. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 2016.09.02
18. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн төсөл 2016.09.19
19. Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2016.11.24. 1/668
20. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл 2016.12.14. 1/699
21. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд 2016.12.16. 1/703
22. Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төсөлд 2016.12.16. 1/703 дугаар албан бичгээр тус тус санал хүргүүлсэн болно.

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан, байнгын хороодын хуралдааны хуваарь, 2016 онд УИХ өргөн баригдсан хуулийн төслийн судалгаа, мэдээлэл гаргаж, Комиссоос санал өгөх хуулийн төслийн талаарх мэдээллийг Комиссын дарга, Ажлын албаны даргад тогтмол танилцуулж байна.

Хууль тогтоомжийн дүн шинжилгээний ажлын хүрээнд 2015-2016 онд УИХ-аас шинээр болон шинэчлэн найруулж баталсан 77 хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан зүйл заалтын түүвэр судалгааг хийв. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоос Хүний эрхийн Үндэсний Комисст хамаарал бүхий нийт 40 хууль тогтоомжид харьцуулсан судалгаа хийж, энэхүү мэдээллээр Ажлын албаны ажилтнуудад сургалт хийв. Мэдээллийг ABLE сүлжээнд байршуулсан болно.

Тахарын Ерөнхий Газартай байгуулсан Санамж бичгийн хүрээнд Тахарын албаны үйл ажиллагаанд холбогдох хуулийн хэрэгжилт, батлагдсан дүрэм журам нь хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхэд нийт 28 дүрэм журам, холбогдох 20 орчим хуульд харьцуулсан дүн шинжилгээ хийв. Хууль тогтоомжийн харьцуулсан дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд ажлын хэсгийн ажилтнуудад эх сурвалжийг ашиглах аргачлалаар сургалт, 3 удаа уулзалт хийж мэдээ, мэдээллээр ханган ажилласан байна.

Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд хүүхдийн сурч боловсрох, эрүүл, аюулгүй байх, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг тусгаж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн холбогдох байгууллагад санал, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах зорилгоор Баян-Өлгий аймагт дахь үндэстний цөөнхийн дотор амьдарч буй хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн судалгааг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Бүх нийтийн боловсролын төлөө үндэсний эвсэл” төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэж байна. “Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт” судалгааны ажлын удирдамжийн дагуу судалгааны баг 2016 оны 12 дугаар сарын 5-22-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Буянт, Цэнгэл, Булган зэрэг 8 сумаас мэдээлэл цуглуулан тайлан бичих ажил хийж байна.

Мөн “Хил хамгаалах ерөнхий газрын харьяа анги, байгууллагын ажилтан, алба хаагчдын Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт, судалгаа хийх удирдамжийн хүрээнд хилийн цэргийн албан хаагчдын хүүхдийн сурч боловсрох эрхийн асуудлыг давхар судалж 17 ангийн 1301 алба хаагчаас авсан санал асуулгын дүнг SSPS программд оруулж, судалгааны мэдээллийг боловсруулах шатанд ажиллаж байна.

“Төрийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрх”, “Хувийн хэвшлийн салбарын хөдөлмөрлөх эрх” гэсэн 2 чиглэлээр судалгааны ажлыг эхлүүлсэн байна. Судалгааны үндсэн зорилго нь төрийн алба хаагч болон иргэдийн хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг судалж, хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрхийн зөрчлийн суурь шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд тусгаж, хөдөлмөрлөх эрхийг хангах бодлого, үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Судалгааны хүрээнд олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн дүн шинжилгээ, холбогдох байгууллагуудын нэгдсэн статистик тоотой танилцаж, судалгааны бүтэц, хүрээг тодорхойлж, судалгааны тайланг боловсруулах ажлыг хийж байна.

Хувийн хэвшлийн салбар дахь хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт судалгааны ажлын хүрээнд ОУХБ-тай уулзалт хийж, судалгааны ажлын төслийн санал боловсруулан хүргүүлсэн нь дэмжигдсэн байна. Тус судалгааг хийх бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэн, судалгааны байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээний төслийг боловсруулсан байна.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлын талаарх илтгэл” боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд ХЭҮК, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж хоёр удаа уулзалт зохион байгуулав. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Монгол Улсын үндэсний тогтолцоо үр дүнтэй ажиллахад тулгарч буй бэрхшээл, ололт амжилтын талаар 11 дүгээр сард жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны бүрэлдэхүүнд багтаж буй нийт 62 байгууллага /УИХТГ, ЗГХЭГ, бүх яамдууд, нутгийн захиргааны, нутгийн өөрөө удирдах байгууллагууд, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл/-аас мэдээлэл цуглуулж байна.

ХЭҮК-ын Ажлын албаны даргын 2016 оны 05 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Аймаг, орон нутагт тодорхой эрхийн чиглэлээр хүний эрхийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх ажлын график”-ийн дагуу Комиссын 21 аймаг дахь ажилтнууд хүний эрхийн тодорхой асуудлаар сар бүр дүн шинжилгээ хийж байна. Энэ нь орон нутгийн хүний эрхийн нөхцөл байдлын ерөнхий дүр зургийг гаргах, байгууллагын дотоод

мэдээлэл солилцооны түргэн шуурхай байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болж байна.


Тайлант хугацаанд эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдал, сонгох, сонгогдох эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, ахмад настны эрх, мэдээллийн ил тод байдал ба мэдэх эрх, гэр бүлийн хүчирхийлэл ба хохирогчийг хамгаалах, төрийн алба хаагчийн хөдөлмөрлөх эрх ба төрийн алба хаших тэгш эрх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, хууль зүйн туслалцаа авах эрх зэрэг сэдвийн хүрээнд аймаг орон нутгаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэн боловсруулж тухай бүр нь Комиссын удирдлага болон ажилтнуудад танилцуулж ажилласан байна.

2016 оны Улсын Их Хурал болон Аймаг, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбогдуулан Комисс олон улсын гэрээ, конвенц, хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны хүртээмж ба MNS 6055:2009 стандартад заасан хэм хэмжээнд нийцүүлэн санал авах байрыг хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэй байдлаар бэлтгэхэд анхаарч ажиллах талаар СЕХ-нд 2016 оны 6 дугаар сарын 6-ны өдөр албан бичиг хүргүүлж, мөн 2016 оны 6 дугаар сарын 23-аас 27-ны өдрүүдэд Комиссын гишүүн Н.Ганбаяраар ахлуулсан ажлын хэсэг Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр, УИХ-ын сонгуулийн 49, 52, 55, 61, 74 дүгээр тойргийн санал авах 20 хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын эрхийн хэрэгжилт, санал өгөх боломж, орчны хүртээмжийн байдалтай танилцлаа.

#### 1.4 Хүний эрх зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч, шалгаж шийдвэрлэх

2016 оны байдлаар Комисс иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 527 гомдол ирүүлснээс 164 нь орон нутгаас ирүүлсэн байна. Ажиллагаанд 32 гомдол байна. Цахимаар 48 гомдол хүлээн авсан байна.

Гомдлын тоог өмнөх жилүүдтэй харьцуулбал:




Комисс 2016 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар цахимаар 7, утсаар 179, биечлэн 1598, нийт 1784 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 34646 минут буюу 577 цаг 26 минутын хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Үүнээс Улаанбаатар хотод 552 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 98 цаг, орон нутагт 1232 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 479 цагийн хууль зүйн зөвлөгөөг тус тус өгч ажиллажээ.



Тайлант хугацаанд БДШХЭБ-ын хэлтсийн дарга Ч.Алтангэрэл 1, ахлах референт Ц.Адьяахишиг 6, референт Г.Золзаяа 4, Захиргаа хамтын ажиллагааны хэлтсийн ахлах референт Х.Мөнхзул 4 нийт 15 гомдолд ажиллагаа хийж, шийдвэрлэсэн байна.

Орон нутаг дахь ахлах мэргэжилтнүүдийг гомдол шийдвэрлэх, Хууль зүйн зөвлөгөө өгөх ажиллагаанд дараах байдлаар оролцуулжээ. Үүнд:

№	Аймгийн нэрс	Орон нутаг дахь ахлах мэргэжилтний нэрс	Хүлээн авсан гомдлын тоо	Хууль зүйн зөвлөгөө өгсөн тоо
1	Архангай	Ж.Очирбат	3	51
2	Баян-Өлгий	Л.Уранчимэг	16	84
3	Баянхонгор	Б.Содонцэцэг	10	80
4	Булган	Д.Мөнхсайхан	15	73
5	Говь-Алтай	Б.Ариунжаргал	7	85
6	Говьсүмбэр	Г.Дэлгэрсүрэн	16	86
7	Дархан-Уул	Ц.Долгорсүрэн	3	52
8	Дорнод	Д.Дугарсүрэн	7	36
9	Дорноговь	Ч.Нандин-Эрдэнэ	1	40
10	Дундговь	Т.Баярцэцэг	4	48
11	Завхан	Ч.Наранхүү	2	67
12	Орхон	Ё.Эрдэнэболд	8	55
13	Өвөрхангай	Т.Осоржамаа	11	24
14	Өмнөговь	Г.Нарангоо	4	36
15	Сүхбаатар	Х.Наранцэцэг	8	60
16	Сэлэнгэ	Д.Гантулга	8	37
17	Төв	У Чойжилсүрэн	5	85
18	Увс	Я.Хонгорзул	11	12
19	Хөвсгөл	М.Тунгалагмөрөн	11	106
20	Хэнтий	Д.Эрдэнэбаясгалан	11	115
21	Ховд	Г.Солонго	3	
	<b>Нийт</b>		<b>164</b>	<b>1784</b>




Иргэний зөрчигдсэн эрхийг сэргээлгэх, учирсан хохирлыг арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах хүрээнд Комиссоос шүүхэд хандаж 4 төлөөлөн нэхэмжлэл гаргасан байна. Үүнд:

- Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэдийн Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хуулиар баталгаажуулсан сайн дурын үндсэн дээр гэр бүл болох, гэрлэлтээ бүртгүүлэх эрхийг хууль бусаар хязгаарлаж, Олон улсын гэрээ,


конвенц болон дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагчийн 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаартай захирамжийг хүчингүй болгуулахаар 2015 оны 12 дугаар сард Дорнод аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан билээ. Үүнийг тус захиргааны хэргийн шүүхийн 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 06 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. Уг шүүхийн шийдвэрийг хариуцагч тал эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан бөгөөд Захиргааны хэргийн шүүхийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл Комиссоос шүүхэд гаргасан төлөөлөн нэхэмжлэлийг шүүх хангаж, Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагчийн 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаартай захирамжийг хүчингүй болгосон байна.

- Иргэний зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, учирсан хохирлыг арилгуулахаар шүүхэд 2016 оны 05 дугаар сард Дорнод аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг гаргасан.
- Хөвсгөл аймгийн сум дундын шүүхэд 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 1/625 дугаар албан бичгээр иргэн Д.Мөнх-Эрдэнийг төлөөлөн эрүүгийн хэрэгт хууль бусаар шалгасны улмаас учирсан хохирол 238,227,592 төгрөгийг төрөөс нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг гаргасан.
- Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 2/637 дугаар албан бичгээр 7 сартай Г.Анандын биед учруулсан гэм хорын хохирол 21,317,821 төгрөгийг Баянгол эмнэлгээс гаргуулахаар, Г.Анандыг төлөөлөн тус тус шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.




2016 оны байдлаар аж ахуйн нэгж, байгууллагад нийт 31 шаардлага, 28 зөвлөмж хүргүүлсэн байна. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг өмнөх онуудтай харьцуулсныг хүснэгтээр харуулбал

### Шаардлага:



### Зөвлөмж:



Комиссын гишүүний 2016 онд хүргүүлсэн зөвлөмжийн дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

№	Хэнд	Явуулсан огноо, дугаар	Хариу ирсэн огноо ба хоног	Зөвлөмжийн агуулга
1	Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал Д.Даваа	2015.12.22 3/41	Хариу ирсэн	Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн сахилгын байр, баривчлах ял эдлүүлэх байрны нөхцөл байдлыг сайжруулах тухай
2	Дархан-Уул аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албаны дарга С.Зул-Очир	2016.01.22 1/01	2016.02.19 01/661	Цагдан хорих байрны нөхцөл байдлыг сайжруулах тухай
3	Дархан Уул аймгийн засаг дарга Н.Баттөр	2016.02.22 2/02	Хариу ирээгүй	Л.Наранжаргалыг хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахгүй байх тухай
4	Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга, туслах комиссар	2016.02.22 3/03	2016.03.22 8в/722	Түр хамгаалах байрны орчин нөхцөлийг сайжруулах тухай

	Ч.Болдбаатар			
5	Монголын хэвлэл мэдээллийн удирдах зөвлөлийн дарга Ч.Номин	2016.02.26 3/04	2016.04.06. 2/133	Бусдын нэр хүндэд халдахгүй байх тухай
6	Монгол Улсын ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2016.03.07 1/05	Хариу ирүүлээгүй	Залуучуудын оролцоог нэмэгдүүлэх тухай
7	Хорих 415 дугаар ангийн дарга, хурандаа Б.Нямгомбо	2016.03.18 3/06	2016.04.11 01/115	Хорих ангийн орчин нөхцөлийг сайжруулах тухай
8	Нийслэлийн прокурор Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Амгаланбаатар	2016.03.22 3/07	2016.04.01 1/1408	Хүүхдийн эрхийг зөрчихгүй байх тухай
9	Дорнод их сургуулийн захирал О.Янжмаа	2016.04.01 2/08	2016.04.28 №54	Хөдөлмөрлөх эрхийн талаар
10	Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн ерөнхий захирал Ц.Оюундарь	2016.05.02 1/09	Хариу ирүүлээгүй	Хөдөлмөрлөх эрхийн талаар
11	Тахарын ерөнхий газрын дарга Ц.Азбаяр	2016.05.20 3/10	2016.06.17 1а/2082	Тахарын ерөнхий газрын Сэжигтэн яллагдагч шүүгдэгч ялтныг хуяглан хүргэх ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах тухай
12	Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Ш.Энхбат	2016.05.23 2/11	2016.06.20 1/662	Хөдөлмөрлөх эрхийн талаар
13	Сүхбаатар аймгийн Боловсролын газрын дарга Л.Байгалмаа	2016.06.17 2/12	2016.08.08 №96	Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх тухай
14	Говьсүмбэр аймгийн Политехникийн коллежийн захирал С.Ууганбаатар	2016.07.06 2/13	Хариу ирүүлээгүй	Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх тухай
15	Хэнтий аймгийн засаг дарга Н.Ганбямба	2016.07.26 1/14	2016.08.25 1/1001	Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийг хөндөхгүй байх, төрийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангах тухай
16	НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын Монгол улс дахь орлогч суурин төлөөлөгч Кевин Галлахер	2016.09.02 1/15	2016.10.10 1/230	Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх тухай

17	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Цагаанхүү	2016.09.19 2/16	2016.09.28 1/2586	Ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах, хуульд заасан цалин, нэмэгдэл хөлс авах эрхийг зохих журмын дагуу эдлүүлэх тухай
18	ГЕГ, МХЕГ, ГИХГ-ын дарга нарт	2016.09.20 1/17	2016.10.20 01/943	Боомтын ажилчдын хөдөлмөрлөх эрхийг хангаж ажиллах тухай
19	Өмнөговь аймгийн засаг дарга Н.Наранбаатар	2016.09.26 1/18	2016.10.28 1-1590	Боомтын ажилчдын хөдөлмөрлөх эрхийг хангаж ажиллах тухай
20	Говьсүмэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ж.Оюунгэрэл	2016.10.07 3/19	2016.11.07 №92	Ялгаварлан гадуурхалтаас ангид байх болон хөдөлмөрлөх эрхийг зөрчихгүй байх талаар тухай
21	Баян-Өлгийн аймгийн засаг дарга А.Глымхан	2016.10.17 2/20	Хариу ирээгүй	Хүүхдийн эрхийг зөрчих байх тухай
22	Өмнөговь аймгийн бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн захирал Д.Энхмандах	2016.10.24 2/21	Хариу ирээгүй	Хөдөлмөрлөх эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
23	Увс аймгийн Боловсролын газрын дарга С.Дашням	2016.10.24 2/22	2016.11.11 №307	Хөгжлийн бэршээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэхээр заасан хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах тухай
24	Говьсүмбэр аймгийн засаг дарга Г.Батсуурь	2016.11.03 3/23	Хариу ирүүлээгүй	Ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлж ажиллах тухай
25	Хууль сахиулах их сургуулийн захирал, профессор, тэргүүн комиссар С.Баатаржав	2016.12.02 3/24	Хугацаа болоогүй	Хүний эрх хичээлийг сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд оруулах тухай
26	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд	2016.12.05 2/25	Хугацаа болоогүй	Зохистой хоол хүнс, орон байраар хангагдах эрхийг хангаж ажиллах тухай
27	Монэнзим мед ХХК-ны гүйцэтгэх захирал Г.Баянмөнх	2016.12.13 2/26	Хугацаа болоогүй	Хөдөлмөрлөх эрхийг зөрчихгүй байх тухай
28	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж	2016.12.13 3/27	Хугацаа болоогүй	Шүүгдэгчийн хувийн байдлыг нарийн шалгаж тогтоож байх, шүүгдэг нарын эрх зүйн байдлыг дордуулахгүй байхад анхаарч ажиллах тухай

Комиссын гишүүний 2016 онд хүргүүлсэн шаардлагын дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

№	ХЭНД	УТГА	ОГНОО	БИЕЛЭЛТ
1 дүгээр сар				

1	Нийслэлийн прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх Б.Амгаланбаатар	Сэжигтэн яллагдагчийн эргэлт уулзалт авах, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхийг хангаж ажиллах тухай	2016.01.06 3/01	Хариу ирсэн
2	Улсын ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан	Прокурорын буруутай үйл ажиллагааны улмаас иргэн Э.Баттулгын чөлөөтэй зорчих эрх зөрчигдсөн тул арга хэмжээ авахуулах тухай	2016.01.20 2/02	Хариу ирсэн
3	Хангайн гурил ХХК-ны захирал С.Нямсүрэн	Жендэрийн тэгш байдлыг хангаж ажиллах тухай	2016.01.29 2/03	Шаардлагад дурдсан асуудлыг шийдвэрлэсэн тухай хариу ирсэн
<b>2 дугаар сар</b>				
4	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ч.Байгалмаа	Л.Батчулуунд Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг нөхөн олгох	2016.02.05 3/04	Хариу ирсэн
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга бригадын генерал Б.Билэгт	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хуулийн дагуу явуулж, хүний эрхийг хангаж ажиллаж тухай	2016.02.08 1/05	Шаардлагад дурдсан асуудлыг шийдвэрлэсэн тухай
6	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл	Баянзүрх дүүргийн засаг дарга Д.Пүрэвдаваад холбогдох асуудлыг шийдвэрлэх тухай	2016.02.23 2/06	Хариу ирсэн
7	Монгол Улсын Ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан	Хорьж мөрдөх хугацаа хэтрүүлэн хорьсон тухай	2016.02.23 2/07	Зөрчил гаргасан прокурорт арга хэмжээ авах тухай хариу ирсэн
<b>3 дугаар сар</b>				
8	Нийслэлийн Багануур дүүргийн засаг дарга Б.Бямбадорж	Хүйтэний улиралд хүүхдээр хурдан морь унуулахгүй байх тухай	2016.03.11 1/08	Хариу ирээгүй
9	Дорнод аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Р.Зоригтбаатар	Хууль зөрчиж гаргасан ИХ-ийн тогтоолыг хүчингүй болгуулах тухай	2016.03.14 3/09	Хариу ирээгүй
10	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга бригадын генерал Б.Билэгт	Үндэслэггүйгээр гав тусгай хэрэгсэл хэрэглэсэн үйлдэлд арга хэмжээ авахуулах тухай	2016.03.15 3/10	Зөрчил гаргасан албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан тухайн хариу ирсэн
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга бригадын генерал Б.Билэгт	Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай	2016.03.18 3/11	Шаардлагад дурдсан асуудлыг шийдвэрлэж байгаа тухай хариу ирүүлсэн
<b>4 дүгээр сар</b>				
12	Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн комиссар Р.Чингис	Хүүхдийн эрхийг зөрчсөн албан тушаалтанд арга хэмжээ авах тухай	2016.04.01 1/12	Арга хэмжээ авсан тухай хариу ирүүлсэн
13	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Л.Насанцэнгэл	Эмчүүлэгчдийн эрхийг хангаж ажиллах тухай	2016.04.12 3/13	Хариу ирсэн. Биелэгдсэн.
14	Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр	Хөдөлмөрлөх эрхийг хангаж ажиллах тухай	2016.04.13 1/14	Хариу ирсэн. Биелэгдсэн.

15	Завхан аймгийн засаг дарга Ж.Жамьянтив	Ажлын байрны бэлгийн дарамтыг таслан зогсоох тухай	2016.04.14 2/15	Хариу ирсэн. Биелэгдсэн.
16	Оюу толгой ХХК-ны захирал Эндрью Вүдлэй	Ажлын байрны дарамтыг таслан зогсоох тухай	2016.04.15 2/16	Хариу ирсэн. Биелэгдсэн.
17	Гадаад хэргийн яамны нарийн бичгийн дарга Д.Ганхуяг	Хөдөлмөрлөх эрхийг зөрчиж байгаа талаар	2016.04.18 2/17	Хариу ирсэн. Биелэгдсэн.
18	Зам, тээврийн сайд М.Зоригт	Тусламж үзүүлэх тухай	2016.04.19 1/18	Хариу ирсэн /тусламж олгох боломжгүй талаар/
19	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт	Зөрчил арилгуулах тухай	2016.04.29 2/19	Хариу ирсэн. Биелэгдсэн.
<b>5 дугаар сар</b>				
20	Увс аймгийн прокурор Г.Эрдэнэбаяр	Зөрчил арилгуулах тухай	2016.05.02 1/20	Хариу ирсэн
21	Говьсүмбэр аймгийн засаг дарга Л.Одсэр	Зөрчил гаргасан албан тушаалтанд арга хэмжээ авах тухай	2016.05.06 2/21	Хариу ирсэн
<b>6 дугаар сард шаардлага хүргүүлээгүй байна.</b>				
<b>7 дугаар сар</b>				
22	Булган аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа О.Ганбат	Эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох тухай	2016.07.01 1/22	2016.07.29 32/02/1083
<b>11 дүгээр сар</b>				
23	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга Г.Туулхүү	Галт зэвсэг тусгай хэрэгсэл хуулийн дагуу хэрэглэх тухай	2016.11.01 3/23	2016.11.07 2а/4235
24	Баян-Өлгий аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын дарга Х.Зауре	Хөдөлмөрлөх болон хүүхдийн эрх зөрчихгүй байх тухай	2016.11.07 3/24	2016.11.24 237
25	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа	Халамжийн тэтгэмжийн мөнгийг нөхөн олгож, түүний эд мөнгөний тусламж авах эрхийг хангах тухай	2016.11.22 2/25	2016.12.07 3/536
<b>12 дугаар сар</b>				
26	Монгол Улсын Ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан	Хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай	2016.12.02 3/26	2016.12.23 4/5236
27	УИХ-ын дэд дарга Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга Я.Санжмятав.	Шүүхийн шийдвэрийг нэн даруй биелүүлж, хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг арилгах тухай	2016.12.07 2/27	2016.12.21 7/5199

28.	Чандмань Увс ХХК-н захирал М.Мөнхөөд	Иргэн Х.Пүрэвдэлгэрийн хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн тухай	2016.12.15 2/28	Хариу ирүүлэх хуулийн хугацаа болоогүй.
29.	УЕП төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан	Иргэн Батцэнгэлийн ял эдлэх хугацаанд эрх зүйн байдлыг дордуулах нөхцөл байдлын тухай	2016.12.19 3/29	Хариу ирсэн 2016.12.21-ний 7/5199
30.	ЦЕГ-ын дарга тэргүүн комиссар Р.Чингист	Иргэн Батцэнгэлийн ял эдлэх хугацаанд эрх зүйн байдлыг дордуулах нөхцөл байдлын тухай	2016.12.30 3/30	хуулийн хугацаа болоогүй.
31.	УЕП төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.ЭнхАмгалан	Иргэн Д.Саранг хуульд ззаснаас илүү хугацааны цагдан хорьсон асуудлаар	2016.12.31 3/31	хуулийн хугацаа болоогүй.
<b>Нийт 31</b>				

Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17.1.2 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний гомдол шийдвэрлэхтэй холбоотой бүрэн эрхийн дагуу нийт 8 гомдолд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцуулах хүсэлтээ албан бичгээр хүргүүлсэн байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлбэл:

№	Огноо, албан бичгийн дугаар	Хаана, хэнд	Утга	Хариу
1	2016.03.02 1/161	Цагдаагийн ерөнхийн газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис	Хүй 7 худагт 2016.02.28-ны өдөр зохион байгуулагдсан хурдан морины уралдааны үеэр Комиссоос хяналт шалгалт хийх явцад ЦЕГ-ын Замын цагдаагийн газрын дарга, хурандаа Ч.Зоригтбаатар нь Комиссын ажлын албаны алба хаагчидтай зүй харьцаж, ёс зүйгүй үйлдэл гаргасан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай	2016.03.04 01/88 Албаны шалгалтаар тогтоогдоог үй гэх.
2	2016.03.18 1/195	Монгол Улсын Ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан	ЧД-н 8-р хорооны иргэн А-г ЭХТА-н 150.3-т заасан хэрэгт холбогдуулан шалгахдаа түүний нөхөр болон охиныг нь Монгол улсын хилээр нэвтрэх эрхийг хууль бусаар хязгаарласан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай	2016.04.14 4/1733 ЭБШХ анхаарч ажиллах үүрэг чиглэл өгөв.
3	2016.03.23 3/199	Цагдаагийн ерөнхийн газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис	Булган аймгийн Цагдаагийн газрын алба хаагчид Архангай аймгийн Өлзийт сумын Хөшөөт багийн иргэд Т, Н нарыг эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгахдаа подвальд 2 хоног хоол ундгүй байлгасан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа ар гэрээс нь эргэлт уулзалт оруулаагүй буюу эрүү шүүлт тулгаж халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн	2016.05.03 4/737 Арга хэмжээ авсан хариу ирсэн.
4	2016.05.11 2/311	Монгол Улсын Шүүхийн ёс зүйн Хороонд	Иргэн А-г хүнд гэмт хэрэгт холбогдуулан шалгахдаа гэм буруутай эсэх нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг үндэслэн ялыг өршөөн хасаж, хугацаанаас нь өмнө тэнсэн	2016.11.10-ны Шүүхийн ёс зүйн хорооны хорооны тогтоол 183



			суллах шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах тухай	ирүүлсэн
5	2016.05.16 1/322	Монгол Улсын Ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан	Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны Цагдан хорих байранд хоригдож буй О-с гаргасан гомдлын дагуу холбогдох шалгалт хийж Увс аймгийн прокурорт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар шаардлага хүргүүлсэн боловч хүний эрхийн зөрчил тогтоогдоогүй байна гэсэн хариу ирүүлсэн тул	2016.06.03 1/2507 Хариу ирсэн.
6	2016.05.23 2/343	Монгол Улсын Ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан	Иргэн О-г хүнд гэмт хэрэгт холбогдуулан шалгахдаа хуульд зааснаас илүү хугацаагаар цагдан хорьсон БЗД-ийн прокурорын газрын хяналтын прокурор Б.Б болон тус хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа мөрдөн байцаагч нарт хариуцлага тооцох	Хариугүй
7	2016.07.011 /22	Булган аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа О.Ганбат	Булган аймгийн Цагдаагийн газрын мөрдөн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Э, эрүүгийн төлөөлөгч Б, Могод сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч А нар иргэн Ө-д эрүү шүүлт тулгаж халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн тул	Хариу ирсэн.
8	2016.11.15 3/653	Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис	Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Н нь иргэн Э-д эрүү шүүлт тулгасан гэх асуудлаар.	Хариу ирсэн.

Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17.1.4 дэх хэсэгт заасан Комиссын гишүүний гомдол шийдвэрлэхтэй холбоотой бүрэн эрхийн дагуу нийт 8 гомдолд талуудыг эвлэрүүлэх замаар асуудлыг шийдвэрлэсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгтээс үзнэ үү.

№	Эвлэрүүлсэн огноо	Гомдолд холбогдогч	Гомдол шийдвэрлэлт
1.	2016.03.02	Говьсүмбэр аймгийн Халамжийн хэлтэс	Говьсүмбэр аймгийн Халамжийн хэлтсээс иргэн А-н халамжийн мөнгийг олгуулсан.
2.	2016.03.11	Нийслэлийн 186 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Батнасан	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Х-н төрсөн охин нь цэцэрлэгт хамруулахаар болсон.
3.	2016.03.14	Говьсүмбэр аймаг дахь Төрийн банкны салбар	Говьсүмбэр аймаг дахь Төрийн банкны салбарт ажиллаж байсан иргэн Ө-н нийгмийн даатгалын дэвтрийг банкнаас буцаан олгуулсан.
4.	2016.03.21	Худалдан авах ажиллагааны газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Ч.Жаргалан	Иргэн Б-н ажлын байрны дарамт, хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг арилгуулсан.
5.	2016.03.22	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын улсын бүртгэлийн ажилтан	Иргэн Н-г улсын бүртгэлд бүртгүүлэх боломжийг олгуулсан.
6.	2016.04.08	Говь-Алтай аймгийн МСҮТ-ийн багш, удирдах албан тушаалтнууд	Говь-Алтай аймгийн Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн Төвийн багш, удирдах албан тушаалтнууд нь тус төвийн 2 дугаар ангид суралцагч суралцагчидыг удаа дараа шалтгаангүй хичээл тасалсан, хоцорсон үндэслэлээр сургуулиас хасах шийдвэр гаргасан нь сурч боловсрох эрх зөрчиж байх тул зөрчлийг арилгуулж, сурч боловсрох эрх хангагдсан.
7.	2016.06.23	Говьсүмбэр аймгийн	Иргэн А-н халамжийн мөнгийг олгуулсан.

		Халамжийн хэлтэс	
8.	2016.11.18	Иргэн Ц	Иргэн М болон иргэн М хоорондын зээлийн асуудал бүрэн шийдэгдсэн.

Гомдол шалгах, хууль зүйн зөвлөгөө өгөх ажиллагааны талаар орон нутаг дахь ахлах мэргэжилтнүүдээс мэдлэг дээшлүүлэх сорилын шалгалтыг 2 удаа авч дүнг танилцуулсан. Эхний шалгалт 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдөр нийт 30 онооны /асуулт тус бүр 1 оноо/ 30 асуулт бүхий шалгалтын материалыг абль программын захидлаар ахлах мэргэжилтнүүдэд нэгэн зэрэг илгээж асуулт бүрээс зөвхөн нэг зөв хариултыг сонгон тодруулж, буцаан илгээх ажиллагаагаар шалгалтыг авч дүгнэсэн байна. Шалгалтын асуултыг зөв хариултын хамт программын олон нийт талбарт байршуулсан. Хоёр дахь шалгалтыг нэгдсэн цугларалтын үед 12 дугаар сарын 19-нд авсан болно.

## ХОЁР. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Тодорхой бүлэгт чиглэсэн хүний эрхийн сургалт, уулзалт

Монгол Улсад хүний эрхийн онолын судалгааг хөгжүүлж буй эрдэмтэн, судлаачид, хүний эрхийн хамгаалагчдын эрдэм судлалын болон практик ажлын үр дүнг нь олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилготой хүний эрхийн цуврал лекцийг 2012 оноос хойш жил бүр 6 удаа буюу нийт 30 лекцийг зохион байгууллаа. 2016 онд дараах сэдвийн хүрээнд олон нийтийн лекц хийлээ.

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын анхны дарга С.Цэрэндорж “Хүний эрхийн үндэсний байгууллага: Чиг үүрэг, ач холбогдол” сэдвээр 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдөр лекц уншив. (53 хүн оролцов)
- Австралийн Квинслэндийн их сургуулийн судлаач, доктор Д.Бямбажав 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдөр “Уул уурхайн салбарт хүний эрхийг хангах нь” сэдвээр лекц уншив. (42 хүн оролцов)
- “Иргэний оролцоо, иргэний нийгэм” сэдвээр 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Өөрчлөлтийн төлөө эмэгтэйчүүд ТББ-ын үүсгэн байгуулагч Х.Номингэрэл лекц уншив. (48 хүн оролцов).
- 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр МУИС-ын ХЗС-ын багш, доктор Д.Гангабаатар “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” сэдвээр лекц уншив. (38 хүн оролцов)5. 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр “Соёлын эрхийн ач холбогдол” сэдвээр Монголын өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч, хууль зүйн ухааны доктор Ч.Амарбаяр лекц уншсан болно. (46 хүн оролцов)
- 2016 оны 12 сарын 19-ний өдөр “Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилт, ажилтан ажил олгогчийн эрх, үүргийн уялдаа” сэдвээр Удирдлагын академийн багш, доктор, профессор Б.Уранцэцэг лекц уншлаа. (58 хүн оролцов)

Лекцийн зар мэдээллийг олон нийтэд нээлттэй зарлаж 2016 онд нийт 285 хүн оролцсон бөгөөд лекц тус бүрийн видео бичлэгийг хийж Комиссын болон Нээлттэй нийгэм форумын цахим хуудас, фэйсбүүк, youtube хуудас зэрэг олон нийтийн сүлжээгээр иргэд татаж үзэх боломжтойгоор байршуулан сурталчилж байна.

Монголын хуульчдын холбоотой хамтран Хуульчийн багц цаг олгох сургалтыг 2016 онд 4 удаа зохион байгуулж, хүний эрхийн 8 сэдвийн хүрээнд Комиссын дарга, гишүүд, Ажлын албаны ажилтнууд нийт 18 цагийн хичээл зааж, сургалтад 200 хуульч оролцсон байна. Үүнд:

1. 2016 оны 3 дугаар сарын 4,6-ний өдөр Хуульчдын холбооны хуульч, өмгөөлөгчдөд Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага сэдвээр, 6 цагийн сургалт, 110 хүнд,
2. 2016 оны 6 сарын 16-ны өдөр Хуульчдын холбооны хуульч, өмгөөлөгчдөд "Хүний эрхийн үндсэн ойлголт" "Хүний эрхэд суурилсан хандлага" "ЭБША-нд оролцогчдын эрх" сэдвээр 4 цагийн сургалтыг, 20 хүнд
3. 2016 оны 11 сарын 16-ны өдөр Монголын Хуульчдын холбооны гишүүдэд "Хүний эрх ба Монгол Улсын Үндсэн хууль", "Жендэр ба хүний эрх" , "Хүний эрхийн олон улсын гэрээ", "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх ба Эрүү шүүлт" сэдвээр,
4. "Хүүхдийн эрх ба хамгаалал" сэдвээр 8 цагийн сургалт, 70 хүнд тус тус зохион байгуулсан байна.

Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хүсэлт, захиалгын дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нийт 361 удаагийн 628,5 цагийн сургалтыг 18733 оролцогчид зохион байгуулсан. Төвийн ажилтнууд 72 удаа 242 цагийн сургалт, 4011 оролцогчид, орон нутгийн ажилтнууд 289 удаа 386,5 цагийн сургалт 14722 оролцогчид тус тус зохион байгуулав.

ТӨВИЙН АЖИЛТНУУДЫН ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ					
Д/д	Огноо	Сэдэв	Оролцогч	Цаг	Оролцогчийн тоо
1	1/23/2016	"Хүний эрхийн хяналт шалгалт, цаашид анхаарах асуудал"	Цэргийн албан хаагчид	1	150
2	16.01.28	"Хүний эрхийн ерөнхий ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага"	Хилийн цэргийн нийт ангийн сэтгэл зүй, мэдээлэл, соёл сурталчилгааны албаны дарга нарын нэгдсэн зөвөлгөөн	1	40
3	2/3/2016	"Хүний эрхийн хяналт шалгалт, цаашид анхаарах асуудал"	Цагдаагийн албан хаагчид	1	150
4	2/4/2016	"Хүний эрхийн зарчим, хандлага, хөгжил"	МIН Group ХХК-ийн ажилтнууд	1	25
5	3/10/2016	ХДХВ/ДОХ ба хүний эрх	Яамдын ХДХВ/ДОХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн, ХӨСҮТ-ийн мэргэжилтнүүд	1	15
6	3/4/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт	Хуульчдын холбооны хуульч, өмгөөлөгчид	3	55
7	3/6/2016	Хүний эрхэд суурилсан хандлага	Хуульчдын холбооны хуульч, өмгөөлөгчид	3	55
8	3/16/2016	ХДХВ/ДОХ ба хүний эрх, Хувийн нууцын талаарх эрх зүйн орчин, ХДХВ,ДОХ ба гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хувийн нууцыг хамгаалахад цагдаагийн ажилтнуудын үүрэг	Улаанбаатар хотын Цагдаагийн байгууллагуудын удирдлагууд	2	18

9	3/23/2016	Орон нутгийн сэтгүүлчдэд зориулсан "Хүний эрхэд суурилсан хандлага ба хэвлэл мэдээлэл /	21 аймгийн хэвлэл мэдээллийн ажилтнууд	8	40
10	3/25/2016	Хүний эрхэд суурилсан хандлага, бизнес ба хүний эрх	Аж ахуйн нэгж компаний захирал, ажил олгогчид, хүний нөөцийн ажилтнууд	1	40
11	3/25-24/2016	МҮЭХ, ХЭҮК, МХЕГ, ХБНГУ-ын Фридрих Эбертийн Сангийн хамтарсан "Хөдөлмөрлөх эрх" бүсийн сургалт	Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн ҮЭ, Комиссын аймаг дахь ажилтан, Мэргэжлийн хяналтын байцаагчид	3	55
12	3/28/2016	Хүний эрхэд суурилсан хандлага ба төрийн үйлчилгээ	Аймаг орон нутгийн мэргэжлийн хяналтын нийгмийн даатгалын байцаагчид	2	25
13	4/1/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага	МУБИС-Нийгмийн ШУ-ны багшийн анги	1	55
14	4/6/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, ХЭҮБ-дын чиг үүрэг ба Комиссын үйл ажиллагаа	Хууль сахиулах их сургуулийн 2-р дамжааны оюутнууд	2	20
15	4/11/2016	Хүний эрхэд суурилсан хандлага, цагдаагийн байгууллага ба хүний эрхийн стандарт	Цагдаагийн СХД дэх 2 дугаар хэлтсийн алба хаагч, ажилтнууд	2	82
16	4/12/2016	Хөдөлмөрлөх эрх, "Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь", "Эрүү шүүлтээс ангид байх эрх"	Хорих 405 дугаар ангийн алба хаагч, ажилтнууд	4	35
17	4/14/2016	"Хүний эрхийн үндсэн ойлголт" "Хүний эрхийн үндэсний байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа"	Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн	2	80
18	4/14/2016	"Хүний эрхийн олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, гэрээний хороодын чиг үүрэг, гомдол гаргах журам", "Хүний эрхэд суурилсан хандлага, зарчмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь", "Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсний улмаас гарах үр дагавар, хариуцлага"	Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийн багш нар	5	20
19	4/19/2016	Хөдөлмөрлөх эрх, "Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь", "Эрүү шүүлтээс ангид байх эрх"	ШШГЕГ-ын харьяа 427 дугаар хорих ангийн алба хаагчид	4	38
20	4/22/2016	Хөдөлмөрлөх эрх, "Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь", "Эрүү шүүлтээс ангид байх эрх"	ШШГЕГ-ын харьяа 411 дүгээр хорих ангийн алба хаагчид	4	10
21	4/28/2016	Хүний эрхийн комиссын үйл ажиллагааны танилцуулга, хүний эрх	Отгонтэнгэр ИС-ийн оюутнуудад	2	20

22	4/28/2016	Хүний эрхийн үндэсний байгууллагын чиг үүрэг, НҮБ-д өргөдөл гомдол гаргах механизм	ХОББИ сургуулийн ахлах ангийн сурагчид	2	25
23	4/29/2016	Хүний эрх ба цагдаагийн байгууллага	ЦЕГ-ын алба хаагчид	2	17
24	5/9/2016	Жендэр ба хүний эрх	Бичил уурхай эрхлэгчид	3	69
25	5/9/2016	Жендэр ба хүний эрх	Бичил уурхай эрхлэгчид	3	35
26	5/10/2016	Жендэр ба хүний эрх	Бичил уурхай эрхлэгчид	3	20
27	5/11/2016	Жендэр ба хүний эрх	Бичил уурхай эрхлэгчид	3	31
28	5/12/2016	Жендэр ба хүний эрх	Төрийн албан хаагчид, иргэд	3	22
29	5/11/2016	Хөдөлмөрлөх эрх, "Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь", "Эрүү шүүлтээс ангид байх эрх"	ШШГЕГ-ын харьяа баривчлах төвийн алба хаагчид	4	16
30	5/11/2016	Хүний эрх, Жендэр, Гэр бүлийн хүчирхийлэл	ЦЕГ-ын шуурхай удирдлага мэдээллийн төвийн алба хаагчид	2	96
31	5/17/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт, ХДХВ/ДОХ ба хүний эрх	Цэргийн албан хаагчид	2	15
32	5/23/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт, ХДХВ/ДОХ ба хүний эрх	Аж ахуйн нэгж компаний захирал, ажил олгогчид, хүний нөөцийн ажилтнууд	2	15
33	5/25/2016	Хүний эрхэд суурилсан хандлага бүхий уул уурхайн аврах үйл ажиллагаа, Хөдөлмөрлөх эрх	ОБЕГ-ын албан хаагчид	4	40
34	5/26/2016	Хүний эрхийн үндэсний байгууллагын чиг үүрэг ба Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа", Хүний эрхийн тухай үндсэн ойлголт", "Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын гишүүн, идэвхтэй, сонгуультан хүний эрхийг хамгаалагч болох нь"	Зүүн бүсийн аймгийн үйлдвэрчний эвлэлийн гишүүн, сонгуульт ажилтнууд, Комиссын орон нутаг дахь ахлах мэргэжилтнүүд, Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналт болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчид	3	65
35	5/31/2016	Жендэр ба хүний эрх	Бичил уурхай эрхлэгчид	3	20
36	6/3/2016	Жендэр ба хүний эрх	Зам тээврийн яамны харьяа Авто тээврийн газрын ажилтнууд	2	140
37	6/6/2016	Хүний эрх ба цагдаагийн байгууллага	ЦЕГ-ын захиалгаар Хууль сахиулах их сургуулийг төгсөж цагдаагийн албанд хуваарилагдаж байгаа сонсогч нар	4	163
38	6/9/2016	"Хөдөлмөрлөх эрх, "Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь", "Эрүү шүүлтээс ангид байх эрх"	ШШГЕГ-ын харьяа хорих 429 дүгээр ангийн алба хаагчид	4	29
39	6/16/2016	"Хүний эрхийн үндсэн ойлголт" "Хүний эрхэд суурилсан хандлага" "ЭБША-нд оролцогчдын эрх"	Өмгөөлөгчид	4	20
40	6/17/2016	ЭБША-нд оролцогчдын эрх	Улсын мөрдөн байцаах газар	1	40

41	8/22/2016	Хүний эрхийн үндэсний байгууллагын чиг үүрэг ба Комиссын үйл ажиллагаа”, “Хүний эрхийн тухай үндсэн ойлголт”, “Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын гишүүн, идэвхтэй, сонгуультад хүний эрхийг хамгаалагч болох нь”	Баруун бүсийн аймгуудын үйлдвэрчний эвлэлийн гишүүн, сонгуульд ажилтнууд, Комиссын орон нутаг дахь ажилтан, МХГ-ын хөдөлмөрийн хяналт болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчид	3	65
42	8/24/2016	“Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хүний эрхийн зөрчил”, “Хүний эрхийн зөрчлийг хянан шийдвэрлэх тогтолцоо, өргөдөл, гомдол шийдвэрлэх нь, “Хууль сахиулах байгууллагын алба хаагчын ёс зүйн дүрэм”	Баривчлах шийтгэл эдлэж буй иргэд	3	100
43	9/14/2016	ХЭҮК-ын танилцуулга, ХЭ-ийн боловсрол	Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн оюутнууд	3	40
44	9/15/2016	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийг ойлгох нь	Нийслэлийн халамжийн мэргэжилтнүүд, Түгээмэл хөгжил төвийн бие даан амьдрах салбар төвийн ажилтнууд, ХБИ, түүний асран хамгаалагчид	2	30
45	9/22/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт, ХЭҮК-ын танилцуулга	СЭЗДС-ийн оюутнууд	1	20
46	9/22/2016 0/02/2016 8 удаа	"Хүний эрх ба Жендэрийн тэгш байдал" бүсчилсэн сургалт	Увс аймгийн Түргэн, Тариалан, Улаангом, Өмнөговь сум, Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Цэцэг сумдын бичил уурхайчид	32	371
47	9/28/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт	Ерөнхий боловсролын Ган-зам 20 дугаар сургуулийн 10, 11 дүгээр ангийн сурагчид, багш нар	2	60
48	10/3/2016	Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт	СХД-ийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс	2	85
49	10/5/2016	Хүний эрхийн стандарт ба цагдаагийн алба	Цагдаагийн байгууллагын алба хаагчид	2	28
50	20/10/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт	УБ хотын Дүүргүүдийн Залуучууд хөгжлийн төвийн ажилтнууд	1	25
51	10/25/2016 3 удаа	Хүний эрх ба Жендэрийн тэгш байдал бүсчилсэн сургалт	Дунговь аймгийн Луус, Хулд, Өлзийт сумдын төрийн албан хаагч бичил уурхайн нөхөрлөл, хувиараа ашигт малтмал олборлогч нарт	12	125
52	11/1/2016	Комиссын танилцуулга, Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрхийн зөрчлийг таних нь	Хууль сахиулах их сургуулийн сонсогч нар	4	35
53	11/7/2016	"Цагдаагийн байгууллагын алба хаагчид үйл ажиллагаандаа баримтлах хүний эрхийн стандарт"	Цагдаагийн албан хаагчид	1	180
54	11/8/2016	Хүний эрхэд суурилсан хандлага, жендэрийн тэгш	Цагдаагийн албан хаагчид	1	83

		байдал			
55	11/14/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт ба эрүүгийн хэргийн оролцогчдын эрх	Монголын Үндэсний дээд сургууль	1	50
56	11/10/2016	Комиссын танилцуулга, Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрхийн зөрчлийг таних нь	Хууль сахиулах их сургуулийн сонсогч нар	4	20
57	11/11/2016	Жендэр ба хүний эрх	Улаанбаатар хотын цагдаагийн II газар	1	50
58	11/11/2016	Хүний эрх ба жендэрийн тэгш байдал	Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн ажилтнууд	6	10
59	11/11/2016	Цагдаагийн байгууллага ба хүний эрх	Нийслэлийн Цагдаагийн газрын Албадан саатуулах төвийн алба хаагчид	1	10
60	11/15/2016	Хүний эрхийн ойлголт ба Эрүүгийн хэргийн оролцогчийн эрх	Монголын Үндэсний их сургууль	2	70
61	11/15/2016	"Цагдаагийн байгууллага ба хүний эрх"	Цагдаагийн албан хаагчид	1	180
62	11/16/2016	Хүний эрхийн тухай үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг ойлгох нь, Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн эрх	"Тэргэнцэртэй фермэрүүдийн холбоо"-ны ажилчид	4	12
63	11/16/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт	"Зөв амьдрах ухаан" ТББ-ын халамжийн байранд амьдарч буй иргэдэд	1	30
64	16/1/2016	Комиссын танилцуулга, Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрхийн зөрчлийг таних нь	Хууль сахиулах их сургуулийн сонсогч нар	3	28
65	11/16/2016	"Хүний эрх ба Монгол Улсын Үндсэн хууль", "Жендэр ба хүний эрх", "Хүний эрхийн олон улсын гэрээ", "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх ба Эрүү шүүлт" сэдвээр, "Хүүхдийн эрх ба хамгаалал"	Монголын Хуульчдын холбооны гишүүд	8	70
66	11/17/2016	Хүний эрхийн ойлголт ба Эрүүгийн хэргийн оролцогчийн эрх	Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн нэг, хоёрдугаар дамжааны оюутнууд	2	158
67	11/18/2016	Хүний эрхийн ойлголт ба Эрүүгийн хэргийн оролцогчийн эрх	Боловсролын их сургуулийн бүрэлдэхүүн Математик, Байгалийн ухааны сургуулийн оюутнууд	2	90
68		Жендэр ба хүний эрх	Төв аймгийн Заамар сумын бичил уурхай эрхлэгчид		

69	24- 25/11/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхийн боловсролын үндсэн ойлголт, Хүний эрхийн түүх, Хүний эрхийн боловсролоор дамжуулж нийгэмд эерэг өөрчлөлтийг бий болгох, Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг практикт хэрэгжүүлэх нь, Залуучуудад хүний эрхийн боловсролыг түгээхэд Залуучууд хөгжлийн төв болон ХЭҮК-ын хамтын ажиллагаа,	Говь-Алтай аймгийн Залуучууд хөгжлийн төвийн ажилтнууд болон гишүүд, дэмжигчид	14	20
70	5/12/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт	Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын алба хаагчид	1	20
71	18/12/2016	ХДХВ/ДОХ ба хүний эрх	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ ажилтнууд	1	20
72	19- 20/12/2016	Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхийн боловсролын үндсэн ойлголт, Хүний эрхийн түүх, Хүний эрхийн боловсролоор дамжуулж нийгэмд эерэг өөрчлөлтийг бий болгох, Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг практикт хэрэгжүүлэх нь, Залуучуудад хүний эрхийн боловсролыг түгээхэд Залуучууд хөгжлийн төв болон ХЭҮК-ын хамтын ажиллагаа,	Орхон аймгийн Залуучууд хөгжлийн төвийн ажилтнууд болон гишүүд, дэмжигчид	14	20

Комиссын орон нутгийн ажилтнуудын зохион байгуулсан сургалт

Д/д	Аймгийн нэр	Сургалт	
		Давтамж/цаг	Оролцогчдын тоо
1	Архангай		
2	Баян-Өлгий	27 (37,8 цаг)	1545
3	Баянхонгор	22 (17,8 цаг)	1061
4	Булган	8 (28 цаг)	602
5	Говь-Алтай	28(19.8 цаг)	1134
6	Говьсүмбэр		
7	Дархан-Уул		
8	Дорнод	8(8.3 цаг)	518
9	Дорноговь	20(11.1 цаг)	651
10	Дундговь	31 (24,9 цаг)	1993
11	Завхан	25 (26.1 цаг)	721
12	Орхон	4(8 цаг)	52
13	Өвөрхангай	14(22.5цаг)	763
14	Өмнөговь	10(19цаг)	310
15	Сүхбаатар	13(22.8 цаг)	960
16	Сэлэнгэ	9 (13цаг)	202
17	Төв	15(18.5 цаг)	629
18	Увс	14(31цаг)	1545
19	Ховд	8(24,9 цаг)	543
20	Хөвсгөл	16 (10 цаг)	519
21	Хэнтий	33(53 цаг)	1490



Сургагч багшийн гарын авлага шинэчлэх ажлын хүрээнд 2016 онд Комиссын ажилтнуудын хариуцах эрхийг шинээр хуваарилж, гарын авлагыг шинэчлэх ажлыг хийсэн. Тус ажилд Комиссын гишүүн П.Оюунчимэг хяналт тавин ажиллаж сургагч багш бүрт хариуцсан эрхийнх нь дагуу зөвлөгөө өгч ажиллав. Сургалтын гарын авлагыг файлжуулж, флаш дискэнд хувилж нийт 22 гарын авлагын ППТ бэлэн болсон байна.

Хүний эрхийн цахим сургалтыг Бодлогын дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтсийн ахлах референт Б.Болорсайхан, референт Г.Золзаяа нар Хүүхдийн төлөө үндэсний газрын хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн төв болон орон нутгийн мэргэжилтнүүдэд 2016 оны 01 дүгээр сарын 25-аас 02 дугаар сарын 26-ны өдөр “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвээр зохион байгуулж нийт 23 хүн хамрагдлаа. Цахим сургалтын явцад тавигдах нийтлэг шаардлага, Батламж авах болзлыг 12 оролцогч хангасан байна.

Цахим сургалтын үр дүнгээс харахад орон нутгаас оролцож буй хүмүүсийн хувьд цаг хугацаандаа даалгавраа гүйцэтгэх, онлайн хэлэлцүүлэгт тухайн оролцогчийн компьютерийн хүчин чадал, интернэтийн сүлжээний найдвартай байдал болон мэдээллийн технологийг ашиглах ур чадвар, оролцогчийн цаг барихтай холбоотой хариуцлагагүй байдал зэрэг асуудал тулгарч байв.

## **2.2 Хүний эрхийн сурталчилгаа**

Хүний эрх” сэтгүүлийн 2016/1, 2016/2 дахь дугаарыг тус тус 1500 хувь хэвлүүлэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглахын зэрэгцээ цахим хэлбэрээр Комиссын цахим номын санд байршуулан олон нийтэд түгээж байна. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн гаргадаг “Хүнийн эрх сэтгүүл”-д нийтлэгдсэн бүтээлүүдийг хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан [www.legaldata.mn](http://www.legaldata.mn)-д байршуулахаар “Оюуны-Инноваци” ТББ-тай хамтран ажиллаж байна.

Мэдээллийг хуудас 2016/1, 2016/2 дугаарыг бэлтгэн “Соёмбо принт” ХХК-иар тус бүр 500 хувь хэвлүүлэв.

Сургалт сурталчилгааны 25 төрлийн (39191хувь) илтгэл, сэтгүүл, сургалтын гарын авлага, брошур зэрэг хэвлэмэл материалыг боловсруулж хэвлүүлэн олон нийтэд түгээлээ. Үүнд:

№	Хэвлүүлсэн материал	Хэвлүүлсэн он сар өдөр	Хувь хэмжээ
1	Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн он жилүүд	2016.01.23	300
2	Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн он жилүүд онол практикийн бага хурлын урилга	2016.01.28	100
3	Хүний эрхийн Үндэсний Комиссын танилцуулга	2016.02.	200
4	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл	2016.04.15	1500
5	Хүний эрх сэтгүүл 2016/1	2016.03.19	500
6	5 төрлийн брошур	2016.04.29	12500
7	Жендэр ба хүний эрх	2016.05.05	500
8	Хүний эрхэд суурилсан хандлага	2016.05.06	500
9	Монгол Улс дахь хорих ангийн хөдөлмөр ба ялтны хөдөлмөр эрхлэлтийн байдал: Эмпирик судалгаа	2016.05.10	500


10	Монгол Улс дахь заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн хөдөлмөр: Бодлого, практикийн дүн шинжилгээ	2016.05.10	500
11	Мэдээллийн хуудас 2016/1	2016.06.20	500
12	Хүний эрхийн цуврал нийтлэлийн эмхэтгэл -2015	2016.11.10	300
13	"Гэрэл татуулсан зам" комик ном	2016.11.25	2000
14	5 төрлийн брошур	2016.12.07	2000
15	Комиссын танилцуулга	2016.12.07	1000
16	Жендэрийн тэгш байдал ба хүний эрх	2016.12.08	766
17	Хүний эрхэд суурилсан хандлага	2016.12.08	500
18	Мэдээллийн хуудас 2016/2	2016.12.10	500
19	Хүний эрх эмхэтгэл	2016.12.15	1500
20	Хүний эрхийн төлөө залуучууд	2016.12.22	1000
21	Хүний эрхийн түгээмэл тунхаглал хялбаршуулсан хувилбар	2016.12.22	1000
22	Хүний эрхийн түгээмэл тунхаглал 30 эрх видео	2016.12.22	1000
23	Хүний эрхийн боловсрол APF гарын авлага	2016.12.22	1500
24	Хүний эрх постер	2016.12.22	8025
25	Бизнес ба хүний эрх	2016.12.26	500
	<b>Нийт</b>		<b>39191</b>

Хүний эрхийн төлөө” сэтгүүлчид клубын уулзалтыг 2016 оны 1 дүгээр сарын 15, 2016 оны 3 дугаар сарын 12, 2016 оны 12 сарын 15-ны өдрүүдэд буюу нийт 3 удаа зохион байгуулсан. Тус уулзалтад БДШХЭБХ-ын дарга Г.Агар-Эрдэнэ, Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн Засаглал, бодлогын асуудал хариуцсан ахлах эксперт Т.Энхцэцэг, ЗХА-ны хэлтсийн дарга Г.Золжаргал нар оролцож хүний эрхийн асуудлууд болон Тогтвортой бичил уурхай төслийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

2016 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Орон нутгийн хэвлэл, мэдээллийн холбоотой хамтран Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн дэмжлэгтэйгээр орон нутгийн сэтгүүлчдэд “Хүний эрхэд суурилсан хандлага ба хэвлэл мэдээлэл” сэдэвт 7 цагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 21 аймгийн телевиз, сонин, мэдээллийн сайтад ажилладаг 43 сэтгүүлч хамрагдав.

2016 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубын сэтгүүлчдийн дунд “Хүний эрхийн хамгаалагчдын эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийн урьдчилсан шатны хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт телевиз, радио, сонин, сайтад ажилладаг 10 сэтгүүлч оролцож сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад тохиолддог нийтлэг бэрхшээлүүдийн талаарх туршлагаа хуваалцаж, саналаа өгөв.

Комисс 2016 онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр өдөр тутмын болон 7 хоног тутмын сонинд 15 удаа, мэдээллийн цахим хуудаст 60 удаа, телевизэд 111 удаа, радиод 13 удаа тодруулга мэдээлэл өгч Комиссоос хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээлсэн байна. Мэдээлэл өгсөн байдлыг сар бүрээр нь харуулбал:




**Олон улсын Хүний эрхийн өдрийг** тусгай төлөвлөгөөний дагуу “Хүн бүрийн эрхийн төлөө зүтгэе” уриан дор зохион байгуулав. Дараахь сурталчилгааны үйл ажиллагааг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хууль сахиулахын их сургуулийн төгсөх дамжааны оюутнуудын дунд “Хүн бүрийн эрхийн төлөө зүтгэе” уралдаант, цэнгээнт АХА нэвтрүүлгийг “Тэнхлэг” студитэй хамтран зохион байгуулж, ТВ9 телевизийн 1-р сувгаар 2016 оны 12 дугаар сарын 5, 6-ны өдөр, ТВ9 телевизийн 2-р сувгаар 12 дугаар сарын 7-ны өдөр нэвтрүүллээ.
- “Байгаль орчны засаглал ба эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх” сэдэвт шилдэг нийтлэл, нэвтрүүлгийн уралдааны удирдамжийг боловсруулан 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдөр бүх сэтгүүлчдэд нээлттэйгээр зарлаж уралдааныг эхлүүллээ. Шилдэг бүтээлийг 2017 оны зургадугаар сарын 22-ны өдөр тодруулна.
- “Дусал цус – Хүнд амьдрал бэлэглэдэг” аяныг Цус сэлбэлт судлалын Үндэсний төвтэй хамтран 12 дугаар сарын 6-ны өдөр зохион байгууллаа. Тус аяныг илүү өргөн цар хүрээтэй болгох, иргэдийг олноор хамруулахын тулд Комиссын олон нийтийн сүлжээнд зурган баннерыг байршуулж сурталчиллав. Түүнчлэн Хүний эрхийн Үндэсний Байгууллага-Иргэний нийгмийн түншлэл 12 дахь уулзалтын үеэр хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууддаа аянд нэгдэхийг уриалав.
- Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Монголын Хуульчдын Холбоотой хамтран төрийн үйлчилгээний нэгдсэн төвд хууль зүйн зөвлөгөө өгөх өдөрлөгийг 12 дугаар сарын 7-9-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг ажлыг олон нийтэд сурталчилах, иргэдийг олноор хамруулах үүднээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэвлэлийн алба, Хуульчдын Холбооны хэвлэлийн албатай хамтран ажилласны дүнд 19 телевиз, өдөр тутмын 7 сонин, 25 мэдээллийн сайтад уг үйл ажиллагааны талаар мэдээлсэн. Энэхүү 3 өдрийн арга хэмжээний үеэр 299 хүнд хууль зүйн зөвлөгөө өгч ажиллав.
- Хүний эрхийн Олон улсын өдрийг тохиолдуулан Комиссын дарга, гишүүд, алба хэлтсийн дарга нар болон референтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ярилцлага мэдээлэл өгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллав. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага мэдээлэл өгсөн хүмүүсийн нэрсийн жагсаалт, цацагдсан огноог дэлгэрэнгүй үзүүлэв.


Д/Д	Хэвлэл мэдээллийн байгууллага	Сэдэв	Огноо	Ярилцлага өгөх хүн

1	UBS	Хууль зүйн зөвлөгөөний асуудлаар	2016.12.07	Г.Агар-Эрдэнэ
2	Htv	Хүний эрхийн олон улсын өдөр, комиссын гомдол хяналт шалгалтын асуудлаар	2016.11.29 12:00-д 40 мин	Т.Ихтамир
3	Ийгл ТВ	Хүний эрхийн бүхий л асуудал	2016.12.01 сар	П.Оюунчимэг
4	VTV ТВ	Комисст ирж буй гомдол түүний шийдвэрлэлтийн асуудлаар	2016.11.29	Л.Дүгэрсүрэн
5	МҮОНРадио	Хүний эрхийн олон улсын өдөр	2016.12.01	П.Оюунчимэг
6	Өнөөдөр сонин	Хүүхдийн эрхийн ярилцлага	2016.12.06	Н.Ганбаяр
7	Үндэсний Шуудан сонин	Хөдөлмөрлөх эрх	2016.12.06	Н.Ганбаяр
8	C1	Хүүхдийн эрх, хүний эрхийн олон улсын өдөр	2016.12.06	П.Оюунчимэг
9	MNC	Хууль зүйн зөвлөгөөний асуудлаар	2016.12.07	Б.Сэмжидмаа
10	News.mn	Хууль зүйн зөвлөгөөний асуудлаар	2016.12.07	Г.Агар-Эрдэнэ
11	Монгол HD	Хүний эрхийн олон улсын өдөр	2016.12.10	Ч.Алтангэрэл
12	UBS	Санамж бичгийн тайлан уулзалт	2016.12.07	Ж.Бямбадорж
13	UBS	Санамж бичгийн тайлан уулзалт	2016.12.07	П.Оюунчимэг
14	NTV	Санамж бичгийн тайлан уулзалт	2016.12.07	Ж.Бямбадорж
15	NTV	Санамж бичгийн тайлан уулзалт	2016.12.07	П.Оюунчимэг
16	Eagle TV	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	П.Оюунчимэг
17	NTV	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	П.Оюунчимэг
18	Ulzii TV	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	П.Оюунчимэг
19	SBN	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	П.Оюунчимэг
20	MNB	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	П.Оюунчимэг
21	Эх орон ТВ	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	Ж.Бямбадорж
22	World TV	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	Ж.Бямбадорж
23	Монцамэ	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	Ж.Бямбадорж
24	Үндэсний мэдээ сонин	Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл	2016.12.05	Ж.Бямбадорж
25	SBN	Наруу 31 ярилцлага	2016.12.07	Ж.Бямбадорж
26	TB5	Хууль зүйн зөвлөгөөний асуудлаар	2016.12.07	Б.Сэмжидмаа

- 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдөр зарласан “Хүн бүрийн эрхийн төлөө зүтгэе” хэвлэлийн бага хурлыг 11 телевиз, 1 радио, 2 сонин ирж сурвалжилсан бөгөөд хэвлэл бага хурлын үеэр анх удаа олон нийтэд цацагдсан бага насны хүүхдийг БНХАУ-д морь унуулж байгаа асуудлыг өдөр тутмын 4 сонин асуудал хөндсөн нийтлэл бичсэн байна.



- Жил бүрийн хүний эрхийн олон улсын өдрийг угтан уламжлал болгон гаргадаг хүний эрхийн өдрийн цахим хуудсын мэдээллийг баяжуулах ажлыг веб мастер Б.Энхтүвшинтэй гэрээ байгуулан хийж, хүний эрхийн олон улсын өдөр олон нийтэд хүргэн сурталчиллаа.
- 2016 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Сүхбаатарын талбайд 12-15 цагийн хооронд “Оролцооны эрхийг баталгаажуулъя” өдөрлөгийг Хүний эрх хөгжил төвтэй хамтран зохион байгуулсан. Уг өдөрлөгийн талаар 7 мэдээллийн сайт мэдээлж олон нийтэд сурталчилсан байна.
- 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдөр Комиссын ажлын албанаас анх удаа “хүн бүрийн эрхийн төлөө зүтгэе” пэйсбүүк челленж аяныг эхлүүлэв. Энэхүү аянд



- 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хотын цагдаагийн газрын хурлын заланд санамж бичиг байгуулан ажиллаж буй байгууллагуудын тайлан уулзалт өдөрлөг болсон. Уг тайлан өдөрлөгийн зарыг олон нийтэд хүргэж UBS, ETV телевизээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.

Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага гарын авлагыг нэгтгэн 1000 хувь, “Бизнес ба хүний эрх” гарын авлагыг 400 хувь, “Жендэрийн тэгш байдал ба хүний эрх” гарын авлагыг 1266 хувийг тус тус хэвлүүлэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд хэрэглэхийн зэрэгцээ Хүний эрхийн цахим номын санд байршуулан олны хүртээл болгож байна.

Эдгээр сургалтын гарын авлагыг Увс, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Төв, Дорноговь аймгийн бичил уурхай бүхий сумдын төрийн албан хаагч, бичил уурхай эрхлэгчид, хувиараа ашигт малтмал олборлогч нарыг хамруулсан “Жендэрийн тэгш байдал” бүсчилсэн сургалтад оролцогчид болон бусад сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд оролцогчдод хүргэлээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсаны 15 жилийн ойд зориулан “Хүний эрхийн төлөө зүтгэсэн он жилүүд” зургийн цомог гаргах ажлыг Комиссын 15 жилийн хугацаанд хийсэн үйл ажиллагааны архивт тулгуурлан бэлтгэж 300 хувийг хэвлүүлэв. Энэхүү цомогийг Хүний эрхийн Үндэсний Комисст ажиллаж байсан үе үеийн ажилтнууд болон хамтран ажиллагч байгууллагуудад хүргэсэн бөгөөд Комиссын 15 жилийн хугацаанд бий болгосон ололт амжилт, дурсамжийг гэрэл зургаар илэрхийлсэн чухал баримт болсон юм.

Хүний эрхийн товч тайлбар номыг Швейцарийн хөгжлийн агентлагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэхээр төлөвлөсөн боловч төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж тус номын оронд Хүний эрхийн брошурыг 2000 хувь хэвлэж орон нутгийн ахлах мэргэжилтнүүдэд хүргүүлэн сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд хэрэглэж байна.

Швейцарын Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2016 оны 9 дүгээр сараас 12 дугаар сарын хугацаанд “Манга Арт” студийн уран бүтээлч Б.Төрмөнхтэй гэрээ байгуулж “Гэрэл татуулсан зөв зам” нэртэй В5 хэмжээтэй, 64 нүүр комик номыг зохиолын дагуу зуруулж, “Адмон” компанид 2000 хувь хэвлүүлэн сургалт сурталчилгаанд ашиглаж байна.

Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил баримтат нэвтрүүлгийг Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн сэтгүүлч Б.Пүрэв гэрээний дагуу гүйцэтгэж 2016 оны 2 дугаар сарын 2-ны өдөр МҮОНТВ-ээр улс орон даяар нэвтрүүлсэн. Түүнчлэн уг баримтат киног Комиссын цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулж хүн бүр нээлттэй үзэх боломжоор хангахын зэрэгцээ сургалт сурталчилгааны үйл ажиллагааны хүрээнд олон нийтэд хүргэж байна.

ТВ9 телевизийн дэргэдэх “Тэнхлэг” студиэр “Гэрэл татуулсан зөв зам” нэртэй, бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хүний эрхийн асуудлыг хөндсөн 13 минутын баримтат нэвтрүүлгийг хийлгэж, 2016 оны 11 дүгээр сарын 27, 28-нд ТВ9 телевизийн 1 дүгээр сувгаар, 11 дүгээр сарын 30-нд 2-р сувгаар нэвтрүүлсэн. Уг нэвтрүүлгийг DVD-гээр 500 хувь хэвлэн хүний эрхийн сургалт сурталчилгаанд ашиглаж байна.

Хүний эрх эмхэтгэлийг 1500 хувь, Хүний эрхийн 5 төрлийн брошурын багцыг 2000, задгайгаар 5 төрлийн брошур тус бүрийг 2500, нийт 12500 хувь хэвлүүлэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглаж байна.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучуудын хөгжил 2013-2017” төслийн хүрээнд “Залуучууд хөгжлийн төв”-ийн үйл ажиллагаагаар дамжуулан нийслэлийн болон орон нутаг дахь эмзэг бүлгийн өсвөр үе, залуучуудад хүний эрхийн боловсрол олгох зорилготой “Залуучууд хөгжлийн төвийн гишүүдэд зориулсан Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд “Хүний эрхийн төлөө залуучууд” сургалтын гарын авлага, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын хялбаршуулсан хувилбар, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” 30 эрх видеог тус бүр 1000 хувь хэвлүүлэн, Залуучууд хөгжлийн төвийн ажилтнуудыг чадавхижуулах сургалт болон сурталчилгааны үйл ажиллагаанд хэрэглэж байна.


Комиссоос ухаалаг гар утсанд зориулан гаргасан "Хүний эрх" аппликэшний мэдээллийг 2016 оны 6 дугаар сард дахин шинэчлэн, шаардлагатай зарим өөрчлөлт, шинэчлэлийг хийж ашиглалтад оруулаад байна. "Хүний эрх" аппликэшнийг хөгжүүлэхэд Би Би Эс Софт ХХК-тай гэрээлэн дараах ажлыг гүйцэтгэв.

- “Хүний эрх” Аппликэшн дахь бүх мэдээллүүдийг шинэчлэх,
- Комиссын веб сайт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор тус аппликэшнд гэмтэл гарч хэвийн ажиллагаа алдагдсан байсныг хэвийн ажиллагаанд оруулах, - Асуулт хариулт хэсэгт нэмэлт цонх үүсгэж хэрэглэгч өөрийн хүссэн асуултыг асуух боломжийг бий болгох,
- Хүний эрхийн талаар уншиж, судлах эх сурвалжуудыг нэмж, шинэчлэн оруулах зэрэг болно.

"Хүний эрх" аппликэшнийг одоогоор Play Store-т байршуулан хэвийн ажиллуулж байгаа ба App Store-т байршуулах хүсэлтийг явуулсан байгаа. ХЭҮК-ын Цахим 21 кампусыг хөгжүүлэх ажлын хүрээнд тус цахим сургалтын талбарыг хэвийн үйл ажиллагаанд оруулж, өмнө ашиглаж байсан сургалтын материал, мэдээллийн баазыг сэргээн оруулж, Комиссын веб сайттай холбон цахим сургалтыг хэвийн явуулах боломжтой болсон.

**Комиссын цахим хуудас**, олон нийтийн сүлжээг хөтлөн явуулах ажлын хүрээнд ХЭҮК-оос хийсэн бүх судалгааны ажил, 2016 оны төсвийн аудитын дүгнэлт, хүний эрхийн цуврал лекцүүдийг бүрэн, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, сургалт, зохион байгуулсан арга хэмжээ, уулзалтын болон ХЭҮК-ын 21 аймаг бүр дэх хуудаст хаяг байршлын зураг мэдээлэл зэрэг нийт 174 мэдээ мэдээлэл, зургийн цомог, видео бичлэгийг шинээр байршууллаа. Цахим хуудаст оруулсан бүх мэдээллийг Комиссын олон нийтийн сүлжээнд байршуулж сурталчилсан.

Комиссын албан ёсны цахим хуудас [www.mn-nhrc.org](http://www.mn-nhrc.org) -т байршсан мэдээллийн тоо (сараар)-г графикаар харуулбал



Комиссын цахим хуудаст 2015 оны 4 дүгээр сараас эхлэн албан ёсоор орон нутгийн ажилтнуудад зориулсан хуудсыг нээсэн бөгөөд 2016 онд цахим хуудаст байршуулсан мэдээллийн тоон үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт
Дорнод		1			4	2			2	2	2	4	17
Сүхбаатар		1	5	2		1			1	1	1		12
Хэнтий		5	5	4	3	1	2		4	2	4	2	32
Дорноговь			2	1		2		1	3	7	4	4	24
Дундговь			1	2	2				5	4	1	1	16
Өмнөговь		1	2	2	2				3	5	2	2	19
Булган	2	4	1	5		1			4	5	3	3	28
Архангай			1	1								3	5
Өвөрхангай				1					1	2			4
Хөвсгөл	1	1	3		2	3			6	4	2	4	26
Сэлэнгэ	1	2	1		1				3	3	3	4	18
Төв		2		2	1				1	4	3	4	17
Завхан		1	5	3	3			1	2	5	3		22
Увс	2	2		2	2	1	1		3	6	5		24
Ховд									5	7	5	5	22
Говь-Алтай	2	2	5	8	3	1	2	2	5	6	4	7	47
Баянхонгор	1		9		5				7	4	2	6	34
Баян-Өлгий			4		2	1				4	1	2	14
Говьсүмбэр	2	1		3	4	1			5	2	2	3	23
Орхон			6	2	1	2			2	2	1	4	20
Дархан-Уул	2												2

Хүний эрхийн цахим номын санд 2016 оны 12 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 302 ном товхимол бүртгэгдсэн Үүнээс 2016 онд шинээр 26 ном бүртгэгдсэний 20 нь Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан ном товхимол, сургалтын гарын авлага байгаа бол 6 нь хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагаас хийсэн судалгааны тайлан, ном товхимол бүртгэгдсэн байна.

2016 онд Хүний эрхийн цахим номын санд нийт 323 хэрэглэгч бүртгүүлсэн байна. Харин Комиссын мэдээлэл лавлагааны төвөөр давхардсан тоогоор 89 хүн үйлчлүүлж 225 ном товхимолыг гэрээр олгож үйлчиллээ.

Хүний эрхийн Цахим номын санд 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс хойш 2016 оны 12 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл нийт 3148 удаагийн хандалт бүртгэгдсэн байна. Хандалтын байдлыг хандалт хийгдсэн улсаар нь авч үзвэл

№	Улс	Хандалтын тоо
1	Монгол	2928
2	Америк	63
3	Орос	29
4	Солонгос	25
5	Австрали	14
6	Англи	13
7	Япон	7
8	Недерланд	7
9	Канад	6
10	Европ	5
11	Франц	4



12	Австри	4
13	Хонконг	4
15	Тайвань	4
16	Герман	3
17	Швейцар	3
18	Хятад	3
19	Энэтхэг	3
20	Протугаль	2
21	Шинэ Зеланд	2

Цахим номын сан нээгдсэнээс хойш хамгийн их хандалттай номуудыг харуулбал:

- Compulsory military service and conscript labour in Mongolia: Review of policy and practice - 1795
- Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар Төрийн бус байгууллагуудаас 2012-2015 онд хийсэн судалгаа, мониторингийн тайлангууд – 1027
- Олон улсын хүний эрхийн билл –852
- Хүний эрхийн товч тайлбар–358
- Хүний эрх сэтгүүл 2015/1 – 564
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл -580
- Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах хүний эрхийн төлөв байдлын судалгаа – 536
- Хүний эрх сэтгүүл 2008/1-409
- “Зохистой аюулгүй хоол хүнсээр жигд, хүртээжтэй хангагдах эрхийн төлөв байдал” судалгаа – 366
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл - 444 удаагийн хандалттай байна.

Хүний эрхийн сургалт, сурталчилгааны хүрээнд Орон нутаг дахь ажилтнуудын хийсэн үйл ажиллагааны нэгдсэн тоон мэдээлэл

д/д	Аймгийн нэр	Нийт үйл ажиллагаа	Сурталчилгаа			
			Хэвлэл мэдээлэл	Цахим	Нөлөөллийн үйл ажиллагаа	Ном, товхимол, брошур
1	Архангай	23	ТВ Яриа -12	14		113
2	Баян-Өлгий		ТВ хэлэлцүүлэг-1			
3	Баянхонгор	36	ТВ Яриа-2	34	Лед дэлгэцээр Шторк 3-4 24 хоног	1457
			Нийтлэл-1			
4	Булган	37	Шторк ТВ-3/17 хоног	28	Лед дэлгэцээр Шторк 2-3 /7 хоног	729
			Шторк ТВ-4/5 хоног			
5	Говь-Алтай	38		47	Лед дэлгэцээр Шторк 21 хоног	1460
6	Говьсүмбэр					
7	Дархан-Уул					
8	Дорнод	8	Шторк ТВ-16 хоног	17	Лед дэлгэцээр Шторк 30 хоног	
9	Дорноговь	32	Радио-3, ТВ яриа-8	24	Лед дэлгэцээр Шторк, мэдээлэл 2 хоног	525
			ТВ Шторк-9			
10	Дундговь	17	Радио-1	24	Лед дэлгэцээр Шторк 4-5 /7 хоног	154
			ТВ-1			
11	Завхан	12	ТВ яриа-3, ТВ шторк-	22		2548

Орхон	10	10 хоног, ТВ зар-14 хоног, Website-1 ТВ яриа-3, ТВ нэвт-1 Радио-2	23	Лед дэлгэцээр Шторк 5 хонлг	81
	29	ТВ яриа-4 Ярилцлага-1 ТВ шторк 12 сар/өдөрт 2	4	Лед дэлгэцээр Шторк 7-8 /30 хоног	164
Өвөрхангай	3		19		150
Өмнөговь	8	ТВ яриа-4, Дэвжээ-1	12		
		Мэтгэлцээн-1 Бэсрэг жүжиг АХА-1	18	Лед дэлгэцээр Шторк, мэдээлэл 23 хоног	47
Сүхбаатар	16				588
Сэлэнгэ	35	ТВ яриа-4	24	Лед дэлгэцээр Шторк мэдээлэл 90 хоног	1065
		Сонины нийтлэл-2			
Төв	26	ТВ Хэлэлцүүлэг-2	22	Лед дэлгэцээр Шторк -4-5/10 хоног	131
Увс					
Ховд	18	ТВ Шторк өдөрт 10 удаа 6 хоног		Лед дэлгэцээр Шторк мэдээлэл 10 хоног	450
Хөвсгөл					
Хэнтий					

#### ГУРАВ: ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрүү шүүлтийн эсрэг элчин сайд хөтөлбөрийн хүрээнд Орхон, Дархан-Уул аймгийн Цагдан хорих байр, Хорих 435, 445 дугаар ангид мониторинг хийх ажлыг 2016 оны 1 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулав. Уг ажлын хүрээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрүү шүүлтээс ангид байх, хүнлэг бус, доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянаж, үнэлэлт дүгнэлт өгч, тогтоогдсон нөхцөл байдлыг цагдан хорих байрны удирдлагуудад урьдчилан танилцуулж, Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлэв.

Швейцарын Холбооны Улсын Женев хотноо болсон “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх элчин сайд” төслийн хаалтын хуралд Комиссын гишүүн П.Оюунчимэг, БДШХЭБХ-ийн Г.Агар-Эрдэнэ нар оролцож, төслийн хэрэгжилтийн талаар тайлан танилцуулав.

Комисс, Гадаад хэргийн яам, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх олон улсын нийгэмлэгээс хамтран “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үүрэг, ач холбогдол” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг болон дугуй ширээний ярилцлагыг 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлэгт ХЭҮК-ын дарга, гишүүд, Гадаад хэргийн яам, Хууль зүйн яам, Улсын Ерөнхий Прокурорын газар, Цагдаагийн Ерөнхий газар, Тахарын Ерөнхий Газар, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг болон хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл 60 гаруй хүн оролцсон байна.

ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих байр болон аймгийн Цагдаагийн газрын харьяа Захиргааны журмаар баривчлах, саатуулах байранд хяналт шалгалт хийх аргачилал зааврыг ГХШХ-ийн ажилтнууд тус тус боловсруулсан байна.

#### 4.1 Гадаад хамтын ажиллагаа

Ази Номхон далайн бүс нутгийн ХЭҮБ-уудын Чуулганыг даргалахтай холбоотой мэдээлэл харилцааг зохицуулах ажлын хүрээнд Норвегийн Вант Улсын нийслэл Осло хотод болсон Цаазаар авах ялын асуудлаарх Дэлхийн Чуулганд Комиссын дарга, Ажлын албаны төлөөлөл оролцож, Монгол Улсын Ерөнхийлөгчийн илгээлтийг чуулганд хүргэж, цаазаар авах ялыг халсан асуудлаар туршлагаа хуваалцлаа. АНУ-ын Нью-Йорк хотод болсон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцид нэгдэж орсон гишүүн улс орнуудын бага хурал болон НҮБХХ/ХЭҮБДХ/ХЭДКГ-ын гурван талт уулзалтад Комиссын дарга, Ажлын албаны дарга нар оролцлоо.

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын зохицуулах хорооны 29 дүгээр хурал 3-р сарын 21-24-ний өдрүүдэд Швейцарийн Холбооны улсын Женев хотноо зохион байгуулагдсан. Хурлаар олон улсад тулгамдаж байгаа хүний эрхийн асуудал болон хүний эрхийн үндэсний байгууллага, бүс нутгийн байгууллага, олон улсын зохицуулах хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн олон асуудал хэлэлцлээ. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга бөгөөд Ази Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы дарга Ж.Бямбадорж “Хүний эрхийн үндэсний байгууллагууд болон бүс нутгийн байгууллагуудаас НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганаас баталсан 2030 он хүртэлх “Тогтвортой хөгжлийн зорилт”-ыг хэрэгжүүлэх талаар эхний үе шатанд авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тухай хуралдааныг даргалаж Ази Номхон далайн бүс нутгийн хэмжээнд Меридагийн тунхаглалын хэрэгжилтийн талаар илтгэл тавьсан болно. Мөн хурлын эхний өдөр бүс нутгийн товч тайланг танилцуулсан.

Тус хуралдааны үеэр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Дани Улсын Хүний эрхийн Хүрээлэнтэй чадавхи бэхжүүлэх, туршлага солилцох, хүний эрхийн боловсролын чиглэлээр тогтмол мэдээлэл солилцох зорилгоор хамтран ажиллах Санамж бичиг байгууллаа.

ОУЗХ-ны дэргэдэх Бизнес ба Хүний эрхийн ажлын хэсгийн гишүүнээр ХЭҮК-ийн гишүүн ажиллахтай холбоотойгоор 2016 онд дараах үйл ажиллагааг явуулав.

- Мароккогийн Вант Улсын Рабат хотод 3 дугаар сарын 2, 3-ны өдөр болсон Бизнесийн холбогдолтой хүний эрхийн зөрчлийг хянан шийдвэрлэх нь сэдэвт семинар, ОУЗХ-ны Бизнес ба хүний эрхийн Ажлын хэсгийн ээлжит хуралд Комиссын гишүүн П.Оюунчимэг оролцлоо. Ажлын хэсгийн тайланд 2015 оны 9 дүгээр сараас 2016 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд бизнес, хүний эрхийн чиглэлээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын явуулж буй үйл ажиллагаа, шийдвэрлэсэн зөрчил гомдлын талаар мэдээлэл бэлтгэж тусгуулав.
- НҮБ-ын ХЭДКГ-аас 4 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Катар улсын Доха хотод зохион байгуулсан Бизнес ба Хүний эрхийн уулзалтад ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг оролцож, “Монголын бизнесийн шинэ, томоохон салбаруудад тулгарч буй хүний эрхийн асуудлууд”, “Шүүхийн бус замаар хохирол барагдуулахад ХЭҮК-ын гүйцэтгэж буй үүрэг” сэдвээр илтгэл, “Цагаач ажилчдын эрхийг хүндэтгэн хамгаалах асуудал”, “Бизнесээс улбаатай хүний эрхийн зөрчил, хохирлыг барагдуулах талаарх туршлага” сэдвээр илтгэл тавьж, мэдээлэл хийв.

НҮБ-ын ХЭДКГ, АНДЧ, ОУЗХ зэрэг олон улсын байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг явуулав.

- Цаазаар авах ялыг халах талаар хийгдсэн өөрчлөлт шинэчлэлийн асуудлаар НҮБХЭДКГ-т мэдээлэл бэлтгэж хүргүүлэв.
- АНДЧ-ын гишүүн байгууллагуудын судалгааны асуулгад хариу бэлтгэж илгээв.
- Ахмад настны эрхийн асуудлаар БНСУ-ын ХЭҮК-оос ирүүлсэн судалгааны асуулгад хариу бэлтгэж илгээв.
- НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчээс ирүүлсэн судалгаанд хариу бэлтгэн явуулав.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд тайлагнах зорилгоор Дээд Комиссарын газраас ирүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаарх судалгаанд хариу бэлтгэн явуулав.
- ЕАБХАБ-ын АИХЭГ, Чех Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ, Тайваний төлөөлөгчийн газрын албаны хүмүүс ирж Комиссын даргатай уулзсан уулзалтуудад урьдчилан мэдээлэл бэлтгэх, орчуулга хийх, тэмдэглэл хөтөлж оролцов.
- ХЭДКГ-аас ирүүлсэн Бодлого, үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын асуудлаарх Ажлын хэсгээс гаргасан асуулгын хариуг явуулав.

Дараах олон улсын хурал, зөвлөгөөн, сургалт, семинарт Комиссын албан хаагчдыг хамруулж, туршлага, мэдээлэл солилцлоо. Үүнд:

- Раул Валленбэргийн Хүрээлэнгээс Тайланд Улсын Бангкок хотноо зохион байгуулж буй зэвсэгт мөргөлдөөний үед болон үүнтэй холбоотой цагаач, дүрвэгсдийн асуудлыг Ази бүс нутгийн хүрээнд авч хэлэлцэх уулзалт /5 сарын 02-05/
- БНСУ-ын ХЭҮК-оос зохион байгуулах хүний эрхийг хамгаалагчдын асуудлаар түншлэл хөгжүүлэх сургалт /5 сарын 16-20/
- Швейцарын Холбооны Улсын Женев хотод болох Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх элчин сайд хөтөлбөр төслийн хаалтын хурал /6 сарын 20-22/
- Ази Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Чуулганаас Малайз Улсын Куала Лумпур хотод зохион байгуулж буй “Эрүү шүүлтийг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт семинар /6-р сарын 14-16/
- ХЭҮБДЧ, АСЕМ-ээс БНСУ-ын нийслэл Сөүл хотод зохион байгуулах ахмад настны эрхийн асуудлаарх тусгай хуралдаан, экспертийн чуулган /6-р сарын 14-16/
- Европын Зөвлөлийн санхүүжилтээр Казахстан Улсын нийслэл Астана хотод 6 дугаар сарын 28-29-ний өдөр “Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үүрэг роль” сэдэвт бага хуралд Комиссын дарга Ж.Бямбадорж оролцож, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа, мандат болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлын талаар илтгэл тавилаа.
- Тайланд Улсын Бангкок хотод болсон Хүний эрхийн боловсролын мэргэжилтнүүдийн чадавх дээшлүүлэх сургалтад /10-р сарын 26-30/
- Турк Улсын Истанбул хотод болсон ХЭҮБ-ыг Төв Азийн орнуудад байгуулах асуудлаарх хуралд Комиссын дарга /1-р сарын 27-28/
- Афганистан Улсын Кабул хотод болсон “Хүний эрх ба тогтвортой хөгжлийн зорилтууд” сэдэвт хуралд Комиссын гишүүн /11-р сарын 26-27/
- Индонези Улсын Балид болсон Азийн хүүхдийн эрхийн дөрөвдүгээр чуулганд Ажлын албаны дарга,

- Швед Улсын Стокгольм хотод болсон “Байгаль орчны менежмент, дэлхийн хөтөлбөр” олон улсын хуралд БДШХЭБХ-ийн дарга тус тус оролцов.

Дараах гадны байгууллагын төлөөлөгчид ирж Комиссын төлөөлөлтэй уулзах ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэв.

- АНУ-ын Төрийн Департментын хүний эрх, хүмүүнлэгийн асуудлын албаны ажилтан хатагтай Шеела Алувалиа, АНУ-ын элчин сайдын яамны Улс төрийн хэлтсийн ажилтан Жеймс Моффитт, Улс төрийн мэргэжилтэн М.Хоролсүрэн нарыг Комиссын гишүүн Н.Ганбаяр 2016 оны 7 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа, цар хүрээ, гүйцэтгэдэг үүрэг, олон улс болон бүс нутгийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажил, Монгол Улсын хүний эрхийн төлөв байдал, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулж, санал солилцов.
- АНУ-ын ЭСЯ-ны Улс төрийн хэлтсийн ажилтан Жэймс Моффит, М.Номин нар Комиссын гишүүн П.Оюунчимэгтэй 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр уулзан жил бүр АНУ-ын Төрийн департаментас боловсруулан гаргадаг Хүний эрхийн тайланд тусгах хүний эрх, эрх чөлөөний анхаарал татсан асуудлаар мэдээлэл авлаа. Уулзалтын явцад хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан хүний эрхийн сургалт, сурталчилгааны төслийн санал боловсруулан АНУ-ын ЭСЯ-наас дэмжлэг хүсч хандахаар тохиров. Үүний дагуу мөрдөн байцаагч нарт ЛГБТИ хүмүүсийн эрхийн асуудлаар үе шаттай сургалт хийх, цагдан хоригдож буй хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хангах, Хууль сахиулахын их сургууль дээр Хүний эрхийн төв байгуулан хөгжүүлэх гурван чиглэлээр төслийн санал боловсруулав.
- ОУХБ-ын бүс нутгийн албаны төлөөлөгчид Комиссын дарга Ж.Бямбадоржтой 2016.09.15-ны өдөр ирж уулзан хамтын ажиллагааны талаар санал бодлоо солилцов. Уулзалтад Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Монгол Улс дахь зохицуулагч Болормаа, БНХАУ-ын Бээжин хот дахь ОУХБ-ын төлөөлөгч Льюкит Париасара, Тайланд Улсын Бангкок хот дахь ОУХБ-ын бүс нутгийн албаны төлөөлөл Рене Роберт, Айлан Пелс, Туркийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөл З.Бибигуль, ХНХЯ-ны мэргэжилтэн Б.Батчимэг, Тогтвортой түншлэлийн тэргүүн С.Ундраа, ШШГЕГ харьяа ХОНХТ-ын дарга Д.Амгалан болон ахлах мэргэжилтэн Я.Сайнжаргал нар болон ХЭҮК-оос дарга Ж.Бямбадорж, гишүүн П.Оюунчимэг, Ажлын албаны дарга А.Дашдэлэг, хэлтсийн дарга Ч.Алтангэрэл, референт Б.Сэмжидмаа, Э.Туул, С.Будрагчаа нар оролцов. Уулзалтын үр дүнд хувийн хэвшлийн байгууллагын ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн судалгаа хийх, судалгааны үр дүнг хэвлэж олон нийтийн хүртээл болгоход ОУХБ-аас дэмжлэг үзүүлэхээр боллоо.
- Япон Улсын ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга ноён Мачида Комиссын гишүүн П.Оюунчимэгтэй 2016 оны 9 дүгээр сарын 15-нд ирж уулзан Японы парламентын зарим гишүүд ЛГБТ хүмүүсийн эрхийн талаар тусгайлсан хууль боловсруулах гэж буйтай холбоотойгоор Японы ЭСЯ-даар дамжуулан бусад улс орны ЛГБТ хүмүүсийн эрх зүйн нөхцөл байдлын талаар судалж байгаага танилцуулав. Комиссын гишүүн Монгол Улсын хууль, эрх зүйн орчинг танилцуулж, нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл авахаар бол ХЭҮК-ын 12 дахь илтгэлтэй танилцахыг санал болгов.
- Азийн Хуульчдын комиссын гишүүн профессор Ан Кион-ван, профессор Филип Хименез нар Комиссын гишүүн Н.Ганбаяртай 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдөр уулзалт хийв.
- АНУ-аас НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд суугаа төлөөлөгч Элчин сайд Кийт Харпер, АНУ-ын ЭСЯ-ны Улс төрийн хэлтсийн дарга Коллин Кренуэлж,

ажилтан Хоролсүрэн нар Комиссын дарга болон гишүүн Н.Ганбаяртай 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдөр уулзалт хийв.

- Дүрвэгсдийн асуудал хариуцсан дээд комиссарын газрын Монгол дахь зохицуулагч Комиссын даргатай уулзах ажлыг зохион байгуулж, уулзалтын мөрөөр Ерөнхийлөгчийн Тамгын газар, Гадаадын иргэн, харьяатын газарт хандан харьяалалгүй иргэдийн асуудлаар мэдээлэл хүссэн албан бичиг илгээв.
- ЖАЙКА-ийн санхүүжилттэй “Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн ахлах зөвлөх Чиба Хисао, төслийн зохицуулагч Исобэ Ёоко, төслийн ажилтан Ц.Одгэрэл нартай ХЭҮК-ын Ажлын албаны төлөөлөл уулзаж, ХЭҮК-ын чиг үүрэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн чиглэлээр хийсэн үйл ажиллагааны мэдээллийг танилцуулав.

ОУЗХ, АНДЧ-ны гишүүнчлэлийн татварыг холбогдох дүрэм журмын дагуу шилжүүлээ.

Хүний эрхийн хараат бус байгууллагын талаар туршлага судлах Вьетнам улсын төлөөлөгчдийг 2 дугаар сарын 29-өөс 3 дугаар сарын 4-ны өдрүүдэд хүлээн авч, үйл ажиллагаагаа танилцуулан, холбогдох байгууллагуудтай уулзууллаа.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хороонд уг конвенцийн хэрэгжилтийн асуудлаар илгээсэн Монгол Улсын Засгийн газрын 8,9-р тайланг судалж, холбогдох мэдээллийг цуглуулан боловсруулж, хөндлөнгийн илтгэл бэлтгэн ЭЯГБХУТК-ын хороонд явуулсан. Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл ХЭДКГ-ын гэрээний хороодын цахим хуудаст нийтлэгдсэн байна.

([http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCEDAW%2fIFN%2fMNG%2f22821&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCEDAW%2fIFN%2fMNG%2f22821&Lang=en)).

Монгол Улсын Засгийн газрын тайлан илтгэлийг НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хороо хэлэлцэхтэй холбогдуулан уг конвенцийн хэрэгжилтийн асуудлаар хүргүүлэх мэдээллийг боловсруулж хүргүүлэв.

#### **4.2 Дотоод хамтын ажиллагаа**

ХЭҮК-ын үүсэн байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2016 оны 2 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд үйл ажиллагааг төлөвлөгөө гарган зохион байгууллаа. “Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” онол практикийн хурал зохион байгуулав. Уг хурлаар өнгөрсөн он жилүүдийн ололт амжилт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, санал санаачилга дээрээ тулгуурлан хүний эрхийн төлөө бүх талын хамтын ажиллагаа, оролцоог эрчимтэй өрнүүлэх зорилгоор хүний эрхийн салбарт ажиллаж байгаа, энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийж буй судлаач, эрдэмтэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлийн илтгэл мэдээллийг онол, практикийн түвшинд хэлэлцэв. Монгол Улсад Хүний эрхийн үндэсний байгууллага байгуулагдсны 15 жилийн ойд зориулан зохион байгуулж буй энэхүү онол, практикийн хурлын үйл ажиллагаанд амжилт хүсч Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга мэндчилгээ ирүүлсэн байна.

Үүний зэрэгцээ Комиссын дэргэдэх ОТБЗ-ын гишүүд, Комисст ажиллаж байсан дарга, гишүүд, ажилтнуудтай уулзалт хийж, үйл ажиллагааны 15 жилийн түүх өгүүлсэн хамтдаа зүтгэсэн 15 жил цомог хэвлүүлэн гардуулав.

Санамж бичгийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах байгууллага бүртэй тухайн жилийн хамтарсан төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ШШГЕГ, Тахар, ЗХЖШ, ЦЕГ, ХХЕГ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд “2016 оны хамтарсан жилийн төлөвлөгөө”-ний саналыг боловсруулан байгууллага тус бүрийн саналыг авч, тусган батлуулах ажлыг зохион байгуулав.

Орон тооны бус зөвлөлийн хурлыг 11 сарын 21 нд зохион байгуулав. Хурлаар Комиссын ойрын үед хийгдсэн томоохон үйл ажиллагааг гишүүдэд танилцуулж, 2017 онд зөвлөлийн хүрээнд хэрэгжүүлэх ажил, мөн олон улсын хүний эрхийн өдрийг угтаж хамтран хийх ажлын тухай хэлэлцэв.

УИХ-аас байгуулсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт Комиссын Ажлын албаны ажилтан төр, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллав. Хуулийг 5 дугаар сарын 19-нд УИХ-ын чуулганаар батлав.

Эмэгтэй удирдагч сан, МОНЭС-тай ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх хүрээнд хамтран ажиллаж, төр төрийн бус байгууллагыг оролцуулсан хамтарсан уулзалт зохион байгуулж, Комиссын гишүүн П.Оюунчимэг оролцож илтгэл танилцууллаа.

МҮНЭ, Фредерих Эбертийн сангаас зохион байгуулж буй хөдөлмөрлөх эрхийн сургалтад Комиссын Ажлын албаны төвийн болон орон нутгийн ажилтнуудыг хамруулав. МОНФЕМНЕТ сүлжээнээс зохион байгуулсан эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн талаарх сургалтад орон нутгийн ажилтныг хамрууллаа.

БНСУ-ын Гууд Нэйборс ТББ-тай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулан, хүүхдийн эрхийн чиглэлээр судалгаа хийж байна.

Төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан ажлын байрны бэлгийн дарамтын асуудлаарх үүргийг нь сануулах үүднээс ЦЕГ, ШЕЗ, УПЕГ-т албан тоот явуулж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хариу мэдээлэл авлаа. Уг мэдээлэлд УЕПГ, ШЕЗ-аас хөдөлмөрийн дотоод журамдаа ажлын байрны бэлгийн дарамтын асуудлаар заалт оруулаагүй байгааг өөрчилж эл асуудлыг тусгахаа илэрхийлжээ.

Хүний эрхийг хамгаалагчдын эрхийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Комиссын дарга Ж.Бямбадоржийн тушаалаар байгуулж, уг ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газартай хамтран ажиллах санамж бичиг шинэчлэн байгуулах ажлыг 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулав.

Хүний эрхийн хамгаалагчдийн эрхийг хамгаалах хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд 12 сарын 15 нд иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлчдээс санал авах уулзалтыг тус тус зохион байгуулав. Мөн ажлын хүрээнд 12 сарын 26 нд ажлын хэсгийн 3 дахь уулзалтыг зохион байгуулж хуулийн төслийн 1-4 зүйлийг хэлэлцэв.

## ТАВ: КОМИССЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 5.1 Комиссыг чадавхижуулах, бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

Комиссын орон нутгийн ажилтнуудтай 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдөр телехурал зохион байгуулж, Комиссын удирдлага 16 аймгийн ахлах мэргэжилтэнтэй ажлын явц, тулгамдаж буй асуудлын талаар ярилцаж, мэдээлэл, зөвлөгөө өгөв.

Комиссын ажилтнуудыг чадавхижуулах дотоод сургалтыг П.Оюунчимэг гишүүн удирдан хуваарь гарган 2016 онд нийт 21 удаагийн сургалт зохион байгуулж Ажлын албаны ажилтнууд бүгд хамрагдав. Үр дүнд нь сургалтын аргачлал, гарын авлагыг сайжруулах ажил хийгдсэн байна. Үүнд:

Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, "Хүний эрхийн олон улсын гэрээ", жендэр ба хүний эрх, гэр бүлийн хүчирхийлэл ба хүний эрх, Сонгох сонгогдох эрх, Амьд явах ба халдашгүй дархан байх эрх, Шүтэх эс шүтэх эрх, "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх", эрүүл мэндээ хамгаалуулах эрх, бизнес ба хүний эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, Хүмүүнлэгийн эрх зүй, "Хүүхдийн эрх", "Нийтийн хэв журам ба хүний эрх", "Хүний эрх ба хорих байгууллага", "Хүний эрхийн боловсрол", "Хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх "Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь", "Хөдөлмөрлөх эрх", "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх" "ХЭҮК-т хамаарал бүхий хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа" сэдвээр тус тус зохион байгуулав.

"Захиргааны ерөнхий хууль" сэдвээр багш Д.Ганзориг А.Сарангэрэл нар хичээл зааж Ажлын албаны ажилтнууд оролцлоо.

Орон нутаг дахь ахлах мэргэжилтнүүд 2016 онд нийт 164 гомдол хүлээн авч Гомдол, хяналт шалгалтын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу шийдвэрлэх ажиллагаанд оролцож, 1232 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 479 цагийн хууль зүйн зөвлөгөө өгч, 289 удаагийн сургалтаар 14722 гаруй хүнийг хамруулан 387 цагийн сургалт зохион байгуулсан байна. Мөн шалгалт судалгааны ажлын хүрээнд төвөөс явуулсан удирдамжийн дагуу мэдээлэл цуглуулж илтгэх хуудас ирүүлсэн байна. Сурталчилгааны ажлын хүрээнд цахим хуудасны дэд цэс, фэйсбүүкэд мэдээлэл оруулах, самбарын мэдээлэл шинэчлэх, ТВ-д мэдээ өгөх, сонинд нийтлэл бичих, ном гарын авлага олшруулж тараах ажил хийсэн байна. Орон нутаг дахь ажилтнууд гомдол шалгаж шийдвэрлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр мэдлэг дээшлүүлэх сорилын шалгалт 2016 онд 2 удаа амжилттай өгөв.

Комиссын хурлыг 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийт 13 удаа хийж нийт 33 асуудал авч хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хурлын бэлтгэл ажлыг хангаж, тэмдэглэлийг хөтөлж баримтжуулсан.

2016 онд Комисст ирүүлсэн нийт 557 албан бичиг, иргэдийн 527 гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу цахим болон журналаар бүртгэн танилцуулж шийдвэрлэлтийн үр дүнг эргэн мэдээлэх ажилд туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Комиссоос нийт 722 албан бичиг, 28 зөвлөмж, 31 шаардлагыг холбогдох байгууллага, иргэдэд зохих журмын дагуу хүргүүлж Удирдлагын цахим программын файлын санд байршуулсан.

Комиссын 2016 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын тайланг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлж, Комиссын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс мэдээллийн самбарт сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг байрлуулав. Комиссын 2017 оны төсвийн төсөл болон 2018-2019 оны төсвийн төсөөлөл, 2016 оны хагас жил, жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж хуулийн хугацаанд нь Сангийн яам, Үндэсний аудитын газар хүргүүлсэн.

НҮБ-ын Хүн амын сан, Хөгжлийн хөтөлбөрийн газар болон Хүүхдийн сангаас авах санхүүжилтийн төсвийг боловсруулав.



Санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хөтлөж, мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллав. Дотоод сүлжээ, компьютер, хэвлэх төхөөрөмжид гарсан гэмтэл доголдлын талаарх дуудлагыг цаг тухай бүр нь засч тохируулав.

Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцүүлж, цахим хуудас хөтлөх журамд 11 өөрчлөлт, 3 нэмэлтийг хийж холбогдох ажилтнуудаас саналыг авч тусган ажиллаж байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудас шинэчлэгдсэн тул 2015, 2016 оны мэдээллийг шивж, холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт цаг тухай бүр хуулийн хугацаанд нь байрлуулан олон нийтэд мэдээлж ажиллав.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн аргачлалын дагуу Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. 2016 оны төлөвлөгөөг батлуулж, 2016.01.25-ны 4/85 дугаар албан бичгээр АТГ-т хүргүүлэв. Мөн авле програмд болон цахим хуудаст Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулж ажилтнууд, олон нийтэд мэдээлэв.

2016 оны ХАСХОМ болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтын дагуу мэдүүлэг гаргагч нийт 21 ажилтан мэдүүлгээ цаасан болон цахим хэлбэрээр хуулийн хугацаанд мэдүүлэв.

Комиссын нийт албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөн, цалин хөлс, үр дүнгийн үнэлгээний мэдээллийг шинэчлэн ТАЗ-ын цахим программд оруулж, 2016.01.04-нд 4/4 дүгээр албан бичгээр тайланг ТАЗ-д хавсралт материалын хамт хүлээлгэн өгсөн.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН

АЖЛЫН АЛБА